



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ

Онгоо
Ууганбаяр АНАР

**ГЭР БҮЛ ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ БА ТУЛГАМДСАН
АСУУДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**



Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн Бакалаврын Зэрэг
Горилсон Дипломын Төсөл

Удирдсан
Д.Оюун /LL.M/

Улаанбаатар. 2025



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ

ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ

Онгоо

Ууганбаяр АНАР

**ГЭР БҮЛ ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ БА ТУЛГАМДСАН
АСУУДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**



Мэргэжлийн индекс

042101

Эрх зүйн Бакалаврын Зэрэг

Горилсон Дипломын Төсөл

Удирдагч: Д.Оюун /LL.M/

Шүүмжлэгч: Ж.Хулан /LL.M/

Улаанбаатар. 2025

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭЛ.....	i
ТАЛАРХАЛ	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	v
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	vi
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	vii
ОРШИЛ	1
I БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ АНГИЛАЛ.....	3
1.1 Гэр бүлийн эрх зүйн харилцааны тухай мөн чанар, ойлголт	3
1.2 Гэр бүлийн эрх зүйн харилцаа үүсэх ба хүчин төгөлдөр байх нөхцөл	4
1.3 Гэр бүлийн эрх зүйн харилцаа дуусгавар болох ба цуцлах үндэслэл	6
II БҮЛЭГ. ГЭР БҮЛ ЦУЦЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА НИЙГМИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	7
2.1 Гэр бүл цуцлалтын эрх зүйн зохицуулалтын ойлголт	7
2.1.1 Гэр бүл цуцлалтад эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр нөлөө болон нөлөөлөгч нийгмийн болон сэтгэл зүйн хүчин зүйлс	10
2.2 Гэр бүл цуцлалтын шалтгаан, харьцуулсан судалгаа	18
2.3 Шүүхийн шийдвэр.....	26
2.4 Гадаад орнуудын гэр бүл цуцлалтын эрх зүйн зохицуулалтын онцлог.....	33
ДҮГНЭЛТ	51
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	53
НОМ ЗҮЙ.....	55

МЭДЭГДЭЛ

Энэхүү дипломын төслийг өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна. Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль (СЭЗИС) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүднээс олон улсын Creative Commons Attribution-NonCommercial-NoDerivs (CC BY-NC-ND) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Нэр: У. Анар

Гарын үсэг:

Огноо: 2026.01.06

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн зөвлөгөө өгч, удирдлагаар хангаж ажилласан удирдагч багш Д.Оюун-д болон эрх зүйн тэнхимийн бүх багш нартаа талархлаа илэрхийлье. Мөн судалгааны ажлыг бичих бүх боломжоор хангасан, дэмжсэн эцэг, эх, гэр бүлдээ гүнээ талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Гэр бүл гэдэг нь нийгмийн анхан шатны нэгж буюу нийгмийн анхдагч бичил хэлбэр бөгөөд энэ нь хүмүүсийн оршин тогтнох үндэс суурь нь болж өгдөг жижиг хэрнээ томоохон агуулгыг өөртөө агуулдаг ойлголт юм. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулинд зааж өгснөөр хуулийн тодорхойлолт нь “гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ гэжээ. Тухайн гэр бүлийн үндэс суурь болсон эхнэр, нөхөр буюу гэрлэгчид нь хоорондоо таарамж муутай эсхүл ямар нэгэн шалтгааны улмаас салах, гэр бүлээ цуцлуулах тохиолдол цөөнгүй гардаг.

Тиймээс энэхүү дипломын ажлын зорилго нь гэр бүл цуцлалтын шалтгааныг эрх зүйн талаас нь судалж, нийгмийн өөрчлөлт болон хууль тогтоомжийн уялдаа холбоог шинжлэхэд оршино. Судалгааны арга зүйд хууль зүйн баримт бичгийн шинжилгээ, статистик мэдээлэлд тулгуурласан дүн шинжилгээ, харьцуулалтын аргыг ашиглан Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтыг судалж, түүний хэрэгжилт, үр нөлөөг гадаад улсын туршлагатай харьцуулан үнэлсэн. Судалгааны үр дүнд гэр бүл цуцлалтын түвшин нэмэгдэхэд эрх зүйн орчны сул тал, гэр бүлийн зөвлөгөө, эвлэрүүлэн зуучлалын тогтолцооны хэрэгжилт хангалтгүй байдал, нийгэм-эдийн засгийн үнэт зүйлийн өөрчлөлт хэрхэн нөлөөлж буйг тогтоов. Иймд гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих эрх зүйн бодлого, урьдчилан сэргийлэх механизмыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Түлхүүр үгс: *гэр бүл, гэр бүл цуцлалт, салалтын шалтгаан, гэр бүлийн тухай хууль, гэрлэгчид.*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Судлагдсан байдлын судалгаа.....	1
Хүснэгт 2.1 Монгол Улсын хэрэг, маргааны төрөл	8
Хүснэгт 2.2 Гэр бүл цуцлалтад нөлөөлөгч нийгмийн болон сэтгэл зүйн хүчин зүйлс ...	16
Хүснэгт 2.3 Гэрлэлт цуцлалтын үндэслэл, 2021-2023 оны байдлаар	18
Хүснэгт 2.4 Шүүхэд гэр бүл цуцлуулах өргөдөл өгсөн үндэслэл	21
Хүснэгт 2.5 МУ-ын одоогийн болон шинэчлэн найруулсан Гэр бүлийн тухай хуулийн төслийн харьцуулалт	22
Хүснэгт 2.6 Гэрлэлт цуцлалтын бүртгэл	27
Хүснэгт 2.7 Шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэсэн гэрлэлт цуцлуулсан хэргийн дүн шинжилгээ	30
Хүснэгт 2.8 Монгол улс болон ОХУ-н гэрлэлт цуцлах эрх зүйн зохицуулалтын ялгаа .	34
Хүснэгт 2.9 Орос улсын гэр бүл цуцлуулах журам	35
Хүснэгт 2.10 Япон улсын гэрлэлт цуцлалтын хэлбэр.....	37
Хүснэгт 2.11 Япон улсын гэрлэлт цуцлалтыг бууруулахад хэрэгжүүлдэг бодлого	39
Хүснэгт 2.12 Их Британий шүүхийн тогтолцоо	42
Хүснэгт 2.13 Их Британи улсын гэр бүл цуцлалтын шалтгаан (2018-2020 он)	43
Хүснэгт 2.14 Өмнөд Солонгос улсын гэрлэлт цуцлах хэлбэр.....	45
Хүснэгт 2.15 БНСУ – Гэр бүл цуцлалтын тоо (2010-2024)	47

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 Гэрлэлтээ батлуулсан хүний тоо, 2020-2024	5
Зураг 2.1 Гэр бүл байсан хугацаагаар гэр бүл цуцлалтын тоо, 2020-2024.....	8
Зураг 2.2 2024 онд шийдэгдсэн гэр бүлийн эрх зүйн маргааны төрөл.....	9
Зураг 2.3 2018-2019 онд амжилтгүй шийдэгдсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	13
Зураг 2.4 АНУ-ын гэр бүл салалтад хүргэдэг гол шалтгаанууд	20
Зураг 2.5 Гэр бүлийн хэргийн иргэний хэрэгт эзлэх хувь (2020-2021 оны байдлаар).....	26
Зураг 2.6 Гэрлэлт цуцлах болсон шалтгаан (2024-2025 оны байдлаар).....	30
Зураг 2.7 ОХУ-ын гэр бүл цуцлалтын тоон үзүүлэлтүүд (2021-2024 оны байдлаар).....	36
Зураг 2.8 Япон улсын гэрлэлт болон гэр бүл цуцлалтын түвшин, 1000 хүнд ногдох байдлаар (1970-2008 он)	39

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**Товчлол****АНУ****БНСУ****МУ****ОХУ****Тайлбар**

Америкийн Нэгдсэн Улс

Бүгд Найрамдах Солонгос Улс

Монгол Улс

Оросын Холбооны Улс

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Нэршил

Тайлбар

Гэр бүл

Гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ.

Гэрлэгчид

Гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэрийг хэлнэ.

Гэр бүл цуцлалт

Хууль ёсны хүчин төгөлдөр гэрлэлтийг шүүх эсвэл эрх бүхий байгууллагын шийдвэрээр дуусгавар болгох үйлдэл юм.

Гэр бүл салалт

Хууль ёсны хүчин төгөлдөр гэрлэлтийг шүүхийн шийдвэрээр эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэрээр түр зуур дуусгавар болгож, эхнэр, нөхрийн хоорондын гэр бүлийн эрх, үүргийг түрдээ зогсоох хууль зүйн үйл ажиллагааг хэлнэ.

ОРШИЛ

Сэдвийн хамрах хүрээ

Энэхүү судалгааны ажил нь гэр бүл цуцлалтын үзэгдлийг эрх зүйн үүднээс судлахад чиглэж, Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн холбогдох зохицуулалт, хэрэгжилтийн үр нөлөөг шинжилсэн. Судалгаанд гэр бүлийн харилцаанд гарч буй зөрчил, түүнийг шийдвэрлэх хууль эрх зүйн механизм, зөвлөгөө болон эвлэрүүлэн зуучлалын тогтолцооны үр ашиг зэргийг хамруулсан. Мөн гэр бүл цуцлалттай холбоотой нийгмийн өөрчлөлт, соёлын үнэт зүйлсийн нөлөөг тодорхойлон, гадаад улсын (ОХУ, Их Британи, Япон, БНСУ) туршлагатай харьцуулалт хийв. Судалгааны хүрээ нь хууль зүйн зохицуулалт болон түүний нийгмийн хүчин зүйлтэй уялдах байдлыг судлан дүгнэхэд төвлөрсөн болно.

Сэдвийн судлагдсан байдал

Хүснэгт 1 Судлагдсан байдлын судалгаа

Судлагдсан ажил	Судлаач	Огноо
“Гэр бүл салалт, гэр бүлийн харилцааны зөрчил шийдвэрлэлтийн талаарх бусад орнуудын туршлага ба Монгол улсын нөхцөл байдал”	Ц. Норовдондог (Ph.D), Д. Аюуш, Д. Амаржаргал (Ph.D), О. Нарантуяа, Д. Жигваагүнсэл, Б. Батцэцэг, Р. Оргилмаа	2022
“Монгол гэр бүлийн бүтэц, хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал”	Б. Оюун-Эрдэнэ /Улаанбаатар Их сургуулийн Гэр бүл судлалын тэнхимийн эрхлэгч/	2017
“Гэрлэлт цуцлалт, түүний үр дагаврыг шийдвэрлэх арга хэлбэрийн асуудал”	Т. Энхжаргал МУИС-ХЗС	1999
“Монголын өнөөгийн гэрлэлт, цуцлалтын байдал”	Ж. Нарантуяа МУИС-ЭЗТ	2002

Судалгааны ажлын зорилго, зорилтууд

- Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль болон холбогдох эрх зүйн зохицуулалтыг судлах.

- Гэр бүл цуцлалтын шалтгаанд нийгмийн өөрчлөлт (эдийн засаг, хотжилт, хүйсийн тэгш байдлын үүргийн өөрчлөлт, соёлын шинэчлэл) хэрхэн нөлөөлж буй талаар дүн шинжилгээ хийх.
- Гэр бүл цуцлалтын эрх зүйн зохицуулалт болон түүний хуулийн практик хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох.
- Гадаад улс орнуудын гэр бүл цуцлалтын хууль тогтоомжийн зохицуулалт, шалтгааны ангиллыг судалж, Монгол Улсын гэр бүлийн эрх зүй, хууль тогтоомжтой харьцуулах.
- Харьцуулсан судалгаанд тулгуурлан Монгол Улсын гэр бүлийн эрх зүй, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, орчин үеийн нийгмийн шинэчлэлд нийцүүлэх санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааны арга зүй

Судалгааны ажлын хүрээнд түүхчлэх арга, хууль зүйн норматив арга, хүснэгт, схем боловсруулан онол, зарчмын судлагдахуунд мэдээллийг харьцуулалтын арга, шүүхийн тайлан, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тайланд тусгагдсан статистик тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эдгээр мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх зэрэг аргыг ашиглан гүйцэтгэнэ.

Шинжлэх ухаан, практикт оруулах хувь нэмэр

Тус судалгааны үр дүнд гэр бүлийн эрх зүйн онолын судалгааг баяжуулах, гэр бүл цуцлалтын шалтгаанд нөлөөлөх эрх зүйн болон нийгмийн хүчин зүйлсийн уялдаа холбоог тодорхойлох ач холбогдолтой. Судалгааны үр дүнд гарсан дүгнэлт, санал, зөвлөмж нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох, гэр бүлийн зөвлөгөө, эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээний үр нөлөөг дээшлүүлэхэд практик ач холбогдолтой юм. Мөн гадаад орны туршлагыг харьцуулан судалснаар Монгол улсад гэр бүлийн эрх зүйн харилцааг хамгаалах бодлогын шинэчлэл хийхэд онолын суурь болон арга зүйн дэмжлэг үзүүлнэ. Ийнхүү уг судалгаа нь гэр бүлийн эрх зүйн хөгжлийг шинжлэх ухааны болон бодлогын түвшинд өргөжүүлэх хувь нэмэр оруулна.

I. БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ АНГИЛАЛ

1.1 Гэр бүлийн эрх зүйн харилцааны тухай мөн чанар, ойлголт

Насанд хүрсэн цагаасаа эхлэн өөрийн сонгосон, амьдралаа холбохоор шийдсэн хүнтэйгээ хамтдаа амьдардаг, хоорондын нарийн нандин холбоо бүхий цусан холбоотой эсхүл хоорондоо гэрлэсэн бүлэг хүмүүсийг гэр бүл гэдэг. Анхдагч нийгмийн томоохон хэсэг болсон гэр бүлийн гол үүрэг нь үр удмаа нөхөн үйлдвэрлэх, түүнийг өсгөн хүмүүжүүлэх явдал юм.

Хууль зүйн хэллэгээр гэр бүл нь гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ. Энэ нь хүний оюун санаа болон материаллаг хэрэгцээг хосолсон сэтгэл зүй, ёс суртахуун, эдийн засаг, эрх зүйн зэрэг харилцааг өөртөө агуулах нарийн нийлмэл тогтолцоо байдаг. (Мөнхжаргал. Т, Гэр бүлийн эрх зүй, 1995 он).

Гэр бүлийг нийгэм-философийн үүднээс эрдэмтэн, судлаачид өөр, өөрөөр тайлбарладаг бөгөөд “Нийгмийн хөгжлийн анхдагч бичил орчин” гэж И. Кант, “Эрэгтэй эмэгтэй хүйсийн болоод нийгмийн тэгш байдлын илэрхийлэл” /Фихте/, “Амьдралын нөхөн үйлдвэрлэл явуулах зориулалттай” /Ф. Энгельс/, “Байгаль, ёс суртахууны холбоо” /Г.В. Гегель/, “Эхнэр ба нөхөр, эцэг, эх ба үр хүүхдийн хоорондын хувийн харилцааны хэв загвар” /Э.Берджесс/ нар тус тус үзсэн байна. Эндээс дүгнээд үзэхэд, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хоорондын харилцаа буюу амьдралын хэв шаардлагаар хамтдаа амьдарч буй хүмүүсийн нэгдлийг гэр бүл гэж хэлдэг гэж ойлгож болох юм.

Хууль зүйн үүднээс энэхүү бичил нийгмийн нэгдэл нь “Гэр бүл, ураг төрөл, үрчлэлт болон өөр ямар нэгэн хэлбэрээр хүүхдийг авч хүмүүжүүлэх ба ёс суртахууны зарчим дээр гэр бүлийн харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоос урган гарсан эрх ба үүргийн холбоотой бүлэг хүмүүс” гэж В.А.Ресянцев үзжээ.

Гэр бүлийн эрх зүйн харилцаа нь гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлтэй холбогдсон гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харилцаа юм. (Дугармаа. А, Гэр бүлийн эрх зүй, 2016 он) Энэхүү харилцаа нь иргэний эрх зүйн харилцааны нэгэн төрөл болох бөгөөд гэр бүлийн гишүүдийн хооронд үүсэх эрх, үүргийн онцлогоор ялгагдана. Энэ нь ёс суртахуун,

хайр, итгэлцэл зэрэг нийгмийн үнэт зүйлтэй нягт холбоотой бөгөөд тухайн харилцаанд оролцогчдын эрхийг хамгаалах, гэр бүлийн эв нэгдлийг хангахад чиглэнэ. Иймээс энэ харилцаа нь зөвхөн эдийн засгийн бус, ёс суртахууны шинж чанартай эрх зүйн харилцаа гэж үздэг.

1.2 Гэр бүлийн эрх зүйн харилцаа үүсэх ба хүчин төгөлдөр байх нөхцөл

Нийгмийн олон төрлийн харилцааны нэгээхэн хэсэг болсон гэр бүлийн эрх зүйн харилцаа нь ч мөн адил үүсэх, дуусгавар болох, өөрчлөгддөг бөгөөд энэ нь олон тал, чиглэл бүхий хүмүүсийн харилцаануудын нэгдэл байдаг гэж ойлгож болох юм. Үүнд гэрлэгчид хоорондын харилцаа, гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүдийн хоорондын харилцаа, гэр бүл, төр хоорондын харилцаа гэх мэт олон харилцаа бүхэлдээ гэр бүлийн харилцаа гэсэн ойлголтыг бүрдүүлдэг.

Гэр бүлийн эрх зүйн харилцаа нь иргэдийн сайн дурын, тэгш эрхийн харилцаан дээр гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлснээр үүсдэг. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулиар гэрлэлтийн насанд хүрсэн эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хооронд сайн дурын гэрлэлт хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд хүчээр, өөр хэлцлийг халхавчлах зорилгоор гэрлэхийг хориглодог. Гэрлэлтийн хүчин төгөлдөр байхын тулд хуульд заасан хориглолт байхгүй байх ёстой. Үүнд:

- Өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа бол;
- Гэрлэгчид хоёулаа эсхүл хэн нэг нь 18 насанд хүрээгүй бол;
- Үрчлэгч, үрчлүүлэгч хоёр гэрлэх;
- Харгалзан дэмжигч, дэмжүүлэгч хоёр гэрлэх;
- Төрөл, садангийн хүмүүс хоорондоо гэрлэх;
- Гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй бол зэрэг орно.

Хуульд заасан гэрлэхэд харшлах нөхцөлийг зөрчсөн, эсвэл гэр бүл болох бодит зорилгогүйгээр гэр бүлээ батлуулсан нь тогтоогдсон нөхцөлд гэрлэгчдийн аль нэгэн, эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн бусад этгээд, мөн хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой. Ийм үндэслэл бий болсон үед шүүх гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох шийдвэр гаргаж болох бөгөөд ингэснээр тухайн гэр бүлийн эрх зүйн харилцаа хүчин төгөлдөр бусад тооцогдон дуусгавар болдог эрх зүйн зохицуулалт үйлчилдэг.

"Гэрлэлт" хэмээх Монгол хэлний үгийн санд оршдог үг нь цаад утгаараа "гэрээ"

гэсэн нэр үгнээс гаралтай бөгөөд энэ нь хоёр хүний хоорондын гэрээ, хэлцэл гэсэн утгыг агуулж байдаг. Монгол улсад төдийгүй дэлхийн ихэнх улс оронд эмэгтэй хүн нэг нөхөр, эрэгтэй хүн нэг эхнэртэй байна гэж заасан байдаг. Онолын хүрээнд төдийгүй амьдрал дээр гэрлэлтийн 4 хэв маяг байдаг бөгөөд энэхүү төрөл нь моногами гэрлэлт буюу “нэг эхнэр, нэг нөхөр” гэсэн уламжлалт хэв шинжийг илэрхийлдэг.

Монгол улсын Гэр бүлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд гэрлэх журмын талаар зохицуулж өгсөн бөгөөд үүнд гэрлэхийг хүсэгчид гэрчийн этгээдийг байлцуулан гэрлэлтээ улсын бүртгэлийн байгууллага, хилийн чанадад ажиллаж буй Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газарт бүртгүүлж, ийнхүү бүртгүүлсэн өдрөөс эхлэн гэрлэгчдийн эрх, үүрэг үүсдэг. Ингэснээр тэдгээр гишүүд нь гэр бүлийн дотор тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх онцлогтой. Гэрлэгчид нь өөрсдийн үзэмжээр эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө ашиглах, эзэмших, захиран зарцуулах, гэр бүлээ төлөвлөх, оршин суух газраа сонгох, өөрийн хуваарьт эд хөрөнгөтэй байх, сэтгэл санааны болон эд хөрөнгийн хохирлоо гэм буруутай этгээдээс гаргуулах тэгш эрх эдэлнэ. Үүргийн хувьд тэдгээр гэр бүлийн хүмүүс нь үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлд шаардагдах санхүүгийн оновчтой нөхцөлийг бүрдүүлэх, харилцан бие биедээ үнэнч шударга байх, халамжлах, туслах, тэжээн тэтгэх, хүндэтгэх, хэн нэгнийхээ эрх, ашиг сонирхлыг хүндэлж, түүнийг нь зөрчихгүй байх, бие биеэ аливаа хүчирхийллийн хэлбэрээр хүчирхийлэхгүй байх болон угийн бичиг хөтлөх үүрэгтэй.

Зураг 1.1 Гэрлэлтээ батлуулсан хүний тоо, 2020-2024



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2024

1.3 Гэр бүлийн эрх зүйн харилцаа дуусгавар болох ба цуцлах үндэслэл

Гэр бүлийн эрх зүйн харилцааны нэгэн төрөл болох гэрлэлт дуусгавар болох гэдэг нь эрх бүхий байгууллагаас гэрлэгчдийн хооронд үүссэн гэр бүлийн харилцааг гэрлэгчид болон бусад сонирхогч этгээдийн хүсэлтээр хуульд заасан үндэслэл журмын дагуу зогсоож буй ажиллагааг хэлнэ. Дуусгавар болох олон үндэслэл байдаг бөгөөд эдгээрийг дурдвал:

- Гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан;
- Гэрлэлт шүүхээс хүчин төгөлдөр бусад тооцогдсон;
- Гэрлэлтийг цуцалсан;
- Гэрлэгчдийн хэн нэгийг шүүхээс нас барсан гэж зарласан зэрэг орно.

Гэрлэлт цуцлах нь гэрлэлт дуусгавар болох хуульд заасан үндэслэлийн нэг бөгөөд гэрлэсний улмаас үүссэн эд хөрөнгийн бус амины эрх болон эд хөрөнгийн эрх, үүргийг цаашид хамтран хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд эрх бүхий байгууллага захиргааны буюу шүүхийн журмаар гэрлэгчдийн хүсэл зоригийн үндсэн дээр гэрлэлтийг дуусгавар болгохыг хэлнэ.

Гэрлэхэд хуульд заасан харшлах шалтгаан байсаар байтал гэрлэсэн, эсхүл гэр бүл болох жинхэнэ зорилгогүйгээр гэрлэлтээ батлуулсан нь тогтоогдвол гэрлэгчдийн хэн нэгний буюу сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох ажиллагааг явуулна. Гэрлэлт цуцлах болон гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох нь хоёулаа гэрлэлтийг дуусгавар болгох үндэслэл боловч эрх зүйн зохицуулалт, хэрэгжих журам, үндэслэл болон үүсгэх эрх зүйн үр дагаврын хувьд харилцан адилгүй ойлголтууд юм.

Гэр бүл цуцлалтын хууль тогтоомжийн зохицуулалт нь хүний анхдагч эрх, эрх чөлөөг хангахын зэрэгцээ гэр бүлийн эв нэгдлийг хамгаалах тэнцвэртэй зарчимд тулгуурладаг. Хууль зүйн үүднээс гэр бүл цуцлалт нь гэрлэлтээ цааш үргэлжлүүлэх боломжгүй болсон нөхцөлд талуудын эрх ашгийг зохистойгоор шийдвэрлэх гол хэрэгсэл болж өгдөг юм. Монгол Улсад Иргэний хэргийн шүүх нь гэр бүлийн маргаанд оролцогчдыг эвлэрүүлэх, хүүхдийн эрх, ашгийг хамгаалах, талуудын эд хөрөнгийн эрхийн шударга хуваарилалтыг хангах үүрэгтэйгээр оролцдог. Энэ нь гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын хүний эрхийн шинж, нийгмийн хамгааллын үүргийг илэрхийлдэг онолын суурь үндэс юм.

II. БҮЛЭГ. ГЭР БҮЛ ЦУЦЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА НИЙГМИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

2.1 Гэр бүл цуцлалтын эрх зүйн зохицуулалтын ойлголт

Ямарваа нэгэн улсын эсхүл дэлхий нийтийн байдлаар хараад үзэхэд гэрлэлтийн нөгөө талд гэр бүл салалт, цуцлалт байдаг нь ойлгомжтой. Зүй нь амьдралын дунд зуурдын тохиолдол, золгүй явдлаар салах бус, насны эцэст хорвоогийн жамаар хагацдаг ч гэсэн амьдрал гэдэг шил, толь шиг тэр тусмаа зах зээлийн ороо бусгаа өнөө үед бүр ч эрээнтэй бараантай. Тэр нь залуу гэр бүлийг төдийгүй тохитой, томоотой, амьдралд хөлөө олсон гэгдэх айл өрхийг нэрмэж, хэвийн амьдралыг бусниулж байна. Энэ талаарх мэдээлэл нэлээд дутагдалтай байдаг. Учир нь нэлээд олон оронд гэр бүл цуцлалтыг нийгмийн гаж үзэгдэл гэж үздэг учир хүмүүс мэдээлэл өгөхөөс нуудаг. (Нарантуяа, Ж. Монголын өнөөгийн гэрлэлт, цуцлалтын байдал, 2002 он)


Гэр бүл цуцлалтыг хууль эрх зүйн анхны хэлбэрт эртний Вавилон улсын Хаммурапи хуулиар МЭӨ 2300 онд зохицуулж өгсөн байдлыг харахад эмэгтэйчүүдийг эрэгтэй хүний өмч, хөрөнгө гэж үздэг байсантай холбоотой бөгөөд хэрэв нөхөр нь тодорхой шалтгаангүйгээр өөрөө хүссэн бол эхнэрээсээ салах эрхтэй байжээ. Еврейчүүдийн дунд гэр бүлээ цуцлуулах эрхийг эрэгтэй хүний ашиг тусын тулд авч үздэг байжээ.

(Comparison of Predisposing and Effective Factors on Divorce Application between Men and Women, WHO, Vol. 6, No. 2, June 2012)

Дэлхий дахин өөрчлөгдөн, мэдээлэл технологийн эрин үед хүмүүсийн харилцаа ч мөн адил давхар өөрчлөгдөж, гэр бүлээ цуцлуулах, өөрийн эрх, үүргийг ухамсарлаж, өөрийн эрх, ашиг сонирхол, мөн хүүхдийнхээ ирээдүйн амьдралын төлөө нууж хаах гэхгүйгээр шүүхээр гэр бүлээ цуцлуулах явдал нэмэгдэж байна.

Монгол улсын Гэр бүлийн тухай хуулинд зааснаар Гэр бүлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасны дагуу гэрлэлтийг хуульд заасан үндэслэлээр захиргааны буюу шүүхийн журмаар цуцалдаг. Гэхдээ үүнд гэрлэлт цуцлаж болохгүй заалт байдаг бөгөөд хариуцагч хүндээр өвчилсөн эсхүл эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй нөхцөлд гэрлэлт цуцлахыг хориглоно.

Зураг 2.1 Гэр бүл байсан хугацаагаар гэр бүл цуцлалтын тоо, 2020-2024



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2024

10 болон түүнээс дээш жил хамтдаа амьдарсан хосууд гэрлэлтээ цуцлуулах үзэгдэл Монгол улсад сүүлийн таван жилийн хугацаанд эрс нэмэгдсэн байна. Гэр бүлийн эрх зүйн онолд авч үзсэнээр гэрлэгчдийн нас нь 30 хүрээгүй, хамтдаа амьдраад таван жил хараахан болоогүй, анхны удаагаа гэр бүл бололцсон хосуудыг залуу гэр бүлд тооцож нийтдээ гурван төрөлд хувааж үздэг байна. (Бүрэнжаргал, Т. Гэр бүлийн социологи. УБ, 2005 он) Мөн статистик үзүүлэлтээр аваад үзэхэд 2024 оны байдлаар Монгол Улсад гэрлэснээс хойш 1-3 жилийн дотор салж байгаа залуу гэр бүлийн хосууд гэр бүл цуцлалтын 13 хувийг эзэлж байгаа нь гэр бүлийн амьдралын эхний үеүдийг залуучууд тэр бүр даван туулж чаддаггүйг харуулж байна.

Хүснэгт 2.1 Монгол Улсын хэрэг, маргааны төрөл

№	Хэрэг, маргааны төрөл	2023 он	2024 он	Өсөлт, бууралт		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү
				Тоо	Хувь	2023 он	2024 он	
1	Нийт шийдвэрлэсэн иргэний хэрэг	63407	73727	10320	16,3%	100%	100%	0,0
2	Иргэний эрх зүйн маргаан	41354	49091	7737	18,7%	65,2%	66,6%	1,4


3	Гэр бүлийн эрх зүйн маргаан	5913	6520	607	10,3%	9,3%	8,8%	-0,5
---	-----------------------------	------	------	-----	-------	------	------	------

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан, 2024 он

Иргэний хэрэг, маргаанд эзлэх гэр бүлийн холбогдолтой хэрэгт ихэнх хувийг нь гэр бүл цуцлахтай холбоотой хэрэг, маргаан эзэлдэг. Гэр бүл цуцлах маргаан нэмэгдэхийн зэрэгцээ энэ нь дан ганц гэрлэлт цуцлах биш үүнд хүүхдийн эрх, ашиг сонирхол, нийгмийн хамгааллын асуудалтай уялдсан шинжтэй маргаанууд нэмэгдэх болсон нь шүүхийн ачааллыг улам нэмэгдүүлэх хандлагатай байна. Энэ нь гэр бүлийн институцийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхөөс гадна нийгмийн халамж, хүүхэд хамгааллын бодлогын ач холбогдлыг улам тодотгож байна.

Гэрлэлтээ цуцлуулсан болон тусгаарласан (салсан) иргэдийн дунд хийсэн судалгаанаас харахад салалтын санаачлагчийн хувьд эмэгтэйчүүд давамгайлж, 50.7%-г эзэлж байгаа бол хосууд харилцан зөвшилцөж, хамтран салалтын шийдвэр гаргасан тохиолдол харьцангуй бага буюу 17.9%-тай байна. Энэ нь гэр бүл цуцлалтын шийдвэр ихэвчлэн нэг талын санаачилгаар хийгдэж байгааг харуулж байна. (ХНХЯ, ХНХСИ, Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт, УБ, 2019 он.)

Зураг 2.2 2024 онд шийдэгдсэн гэр бүлийн эрх зүйн маргааны төрөл



Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан, 2024 он

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэр бүлийн тухай хууль нь анх 1999 оны 6 сарын 11-ны өдөр батлагдан 1999 оны 8 сарын 1-ны өдрөөс эхлэн хэрэгжсэн бөгөөд манай улсын гэр бүлийн эрх зүйн бүхий л харилцааг зохицуулж байгаа томоохон суурь хууль болсон билээ. Хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн цагаасаа хойш 2002, 2010, 2011, 2012, 2016, 2018, 2021 болон 2022 онуудад нийтдээ 8 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэ нь гол төлөв манай улсын бусад хуулийн

өөрчлөлт, шинэчлэлийг дагалдан зохицуулагдсан болох нь хуулийн зохицуулалтуудаас харагддаг. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүдэд тусгагдсан заалтуудад гэрлэх, гэрлэлт цуцлах, хүүхдийн эрх, ашиг сонирхол хөндөгдөх, ямар нэгэн байдлаар зөрчигдөх, түүнийг сэргээх арга зам зэргийг тусгаж өгснөөрөө онцлог боловч нэг сул тал нь үүнээс үүсэх үр дагаврыг нарийвчлан хуульчлаагүйд байгаа юм. (Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар танилцуулга, Хууль зүй дотоод хэргийн яам, 2025 он)

Иймээс Монгол Улсын Их Хурал 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан “Шүүх байгуулах тухай хууль”-иар нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг, мөн улсын хэмжээнд Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүхийг байгуулахаар хуульчилсан байна. Эдгээр шүүх нь 2026 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх бөгөөд манай улсад Гэр бүл, хүүхдийн хэргийг дагнан шийдвэрлэх шүүх байгуулагдах гэж байгаа нь онцлууштай. 2019 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн” ТББ-аар хэргийн дагнан шийдвэрлэх “Улаанбаатар хотод гэр бүл, өсвөр насны хүний хэргийн шүүх, танхим байгуулах” тухай тандан судалгаа хийлгэсэн бөгөөд судалгаагаар “...гэр бүлийн дагнасан шүүх байгуулах хэрэгцээ, шаардлага үүссэн” гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. (Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээний тайлан, 2025 он)

2.1.1 Гэр бүл цуцлалтад эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр нөлөө болон нөлөөлөгч нийгмийн болон сэтгэл зүйн хүчин зүйлс

Монгол Улсын эрх зүйн тогтолцооны хувьд Англи-Америкийн болон эх газрын загварын холимог тогтолцооны хэв шинжтэй. Шүүхийн ерөнхий зөвлөл нь Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийг байгуулахын хамт анхан шатны шүүх дэх орон тооны болон орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч одоогийн байдлаар улсын хэмжээнд 41 анхан шатны шүүхэд нийт 44 эвлэрүүлэн зуучлагч, тэдгээрийн туслахуудын хамтаар ажил үүргээ гүйцэтгэн мөн төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь эвлэрүүлэн зуучлагчдыг сонгон ажиллуулахаар хуульд зохицуулсан байна. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 800 гаруй орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч эрх авч, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. (Хууль зүйн үндэсний хүрээлэн. Эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх ажиллагаа гарын авлага, 2015, 49 дэх тал.)

Гэрлэлтийг шүүхээр цуцлахын өмнө эвлэрүүлэх арга хэмжээг заавал хэрэгжүүлэх зохицуулалтыг Япон улс баримталдаг. Монгол Улсын Эвлэрүүлэн

зуучлалын тухай хуулийг боловсруулах явцад Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) оролцсон нь гэр бүлийн харилцаанд хандах Японы бодлого, соёлын зарим ойлголт манай эрх зүйн зохицуулалтад тодорхой хэмжээнд туссан байх боломжтойг харуулж байна.

Монгол улсын Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-14.3-т заасны дагуу гэрлэлтээ шүүхээр цуцлуулахаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд заавал эвлэрүүлэн зуучлалын тогтолцоонд хамрагдах бөгөөд шүүх талуудад 1-3 хүртэл сарын хугацаанд бодитойгоор эвлэрэх боломж олгоно. Хэрэв энэ хугацаанд талууд эвлэрч чадвал гэр бүл цуцлуулах нэхэмжлэлээ хүчингүй болгох боломжтой. Харин эвлэрүүлэн зуучлал амжилт олоогүй тохиолдолд шүүх гэрлэлтийг албан ёсоор цуцалж, хүүхдийн асрамж, тэтгэлэг болон гэр бүлийн эд хөрөнгийн эрхийн талаар эцсийн шийдвэр гаргана.

Энэ нь гэр бүл нийгмийн үндсэн бүтэц, хүн амын хөгжил тогтвортой байдлын тулгуур гэж үздэгтэй холбоотой. Иймээс төрөөс хэрэгжүүлж буй бодлого нь гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжиж, хүүхдийн эрх, ашиг сонирхол хөндөгдөхгүй, хүмүүжилд сөргөөр нөлөөлөхгүй байх нөхцөлийг хангахад чиглэдэг. Үүний үр дүнд шүүх гэрлэлтийг шууд цуцлахаас зайлсхийж, боломжтой тохиолдолд хосуудыг эвлэрүүлэх, гэр бүлийн харилцааг сэргээх боломжийг эрэлхийлэх арга хэмжээг түлхүү хэрэгжүүлж иржээ.

Гэр бүлийн маргаантай холбоотой эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд эвлэрүүлэн зуучлагч нь сургалт явуулах үүрэг хүлээдэггүй бөгөөд нөхцөл байдлаас хамааран сэтгэл зүйн дэмжлэг авахыг талуудад санал болгох, түүнчлэн тэдний хүсэлтийн дагуу гэр бүлийн гишүүн, төрөл садан болон бусад холбогдох этгээдийг уг ажиллагаанд оролцуулах боломж бүрдүүлдэг. Урьдчилан шийдвэрлэхээр шүүхээс гадуурх журмаар явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтад хүрээгүй тохиолдол нь иргэний хэрэг шүүхэд үүссэний дараа гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дахин явуулахыг хориглох үндэслэл болдоггүй. Харин шүүхээс тогтоосон хугацаанд гэрлэгчид эвлэрэлд хүрээгүй тохиолдолд гэрлэлт цуцлахаас бусад, тухайлбал дундын эд хөрөнгө, тэтгэмж, тэтгэлэгтэй холбоотой маргааныг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх боломжтой байдаг.

Энэхүү шалгуур нь хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг ба сөрөг үр дагавар, мөн хэрэгжилтийн явцад тулгарч буй хүндрэл,


бэрхшээлийг тодорхойлоход чиглэдэг. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын захиалгаар хийгдсэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн судалгаанд оролцсон шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчдын ярилцлагаас үзэхэд, гэр бүлийн маргаан практикт хамгийн их орж ирдэг байна. Ялангуяа хотын захын дүүргүүдэд эдийн засгийн хүндрэл, амьжиргааны асуудлаас шалтгаалсан гэр бүл цуцлах маргаан зонхилж байгаа бол орон нутагт маргааны тоо харьцангуй цөөн, эвлэрэх боломж илүү байдаг ажээ.

Гэвч олон жил тусдаа амьдарсан, шинэ хамтран амьдрагчтай болсон, бүр хүүхэдтэй болсон талуудын маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа үр ашиггүй байгааг онцолсон байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой маргааныг шүүх зарим тохиолдолд хүчирхийлэл нотлогдсон тохиолдолд л хүлээн авч, бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлалд буцаадаг нь практикт хүндрэл үүсгэж байна. Учир нь сэтгэл санаа, эдийн засгийн зэрэг хүчирхийлэл нь бие махбодийн хүчирхийлэл шиг нотлох баримтаар шууд тогтоогдохгүй байх нь элбэг бөгөөд энэ нь иргэдийг дахин дахин шүүх, эвлэрүүлэн зуучлалын шат дамжлага дамжуулах, улсын тэмдэгтийн хураамжийг дахин дахин төлүүлэх нөхцөлд хүргэж байна.

Иймээс гэр бүлийн тогтвортой байдал, хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг заавал явуулах зохицуулалт нь бодит нөхцөлд бүрэн хэрэгжих боломжгүй байгааг дээрх ярилцлага тодорхой харуулж байна.

2018 онд шүүхийн эвлэрүүлэн зуучлалд нийт 2995 гэр бүлийн маргаан ирснээс 412 буюу 13.7% нь амжилттай эвлэрсэн үзүүлэлттэй бол 2019 онд ирсэн 3020 өргөдлийн 377 нь буюу 12.4% нь л эвлэрүүлэн зуучлалын үе шатанд амжилттайгаар шийдвэрлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, эдгээр хоёр жилд гэр бүлийн маргааны 86 орчим хувь нь эвлэрүүлэн зуучлалаар шийдэгдээгүй гэсэн үзүүлэлттэй байна. 2020 онд эвлэрүүлэн зуучлалд шилжсэн 3015 маргааны 88% нь үр дүнд хүрээгүй, 2021 онд мөн адил 3861 гэр бүлийн маргааны 88%-д талуудын эвлэрүүлэн зуучлал үр дүнтэй болоогүй гэсэн үзүүлэлт гарчээ.

Зураг 2.3 2018-2019 онд амжилтгүй шийдэгдсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа



Эх сурвалж: Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг ТББ, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, 2020 он, 59 дэх тал.

Судлаачдын тэмдэглэснээр хүчирхийллийн шинжтэй аливаа хэрэг, тэр тусмаа гэр бүлийн холбогдолтой маргаанд ямарваа нэгэн хүчирхийллийн шинж байвал тус нэхэмжлэлийг шүүхэд хүлээн авахдаа түүнд тавигдах шаардлага, холбогдох нотлох баримтыг үндэслэлгүйгээр шаардаж өчүүхэн шалтгааны улмаас шалтаг заан буцаахгүй байхад түлхүү анхаарах хэрэгтэйг дурджээ. (Дугармаа, Б. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019 он, №4, 112 дахь тал.)

ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4-т заасан нөхцөл байдал үүссэн гэж үзэхэд практикт ихэвчлэн бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл үйлдэгдсэнийг нотолсон байхыг шаарддаг. Энэ нь сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийллийг баримтаар нотлох нь бодит байдал дээр хүндрэлтэй байдагтай холбоотой юм. Гэвч сэтгэл санааны хүчирхийлэл нь заавал хүний амь нас, эрүүл мэндэд бодит, материаллаг хохирол учруулснаар илэрч, тогтоогдох албагүй.

Гэр бүлийн хүчирхийлэл нь зөвхөн бие махбодын бус, эдийн засаг, сэтгэл зүйн хэлбэртэй, давтамжтай явагддаг бөгөөд хор уршиг нь шууд хэмжигддэггүй. Хүчирхийлэлтэй орчинд өссөн хүүхэд шууд өртөөгүй байсан ч ноцтой сөрөг нөлөөг амсдаг. Иймээс эвлэрэх боломжгүй нөхцөлийг зөвхөн бие махбодын болон бэлгийн хүчирхийллээр хязгаарлах нь хангалтгүй юм.

Гэр бүлийн хүчирхийллийн эдийн засгийн хэлбэр нь эдийн засгийн хараат байдалд оруулах, эд хөрөнгийн хохирол учруулах замаар илэрдэг бөгөөд амь нас, эрүүл мэндэд учруулсан хор уршиг шиг шууд хэмжигдэж, тогтоогдох боломжгүй онцлогтой.

Гэр бүлийн хүчирхийлэл нь ихэвчлэн давтамжтай, үргэлжилсэн шинжтэй байдаг. Гэр бүл цуцлалт нь хүчирхийллийн нэг үр дагавар боловч хүчирхийлэлтэй орчинд өсч буй хүүхдийн бие махбод, сэтгэл зүй, нийгэмших үйл явцад ноцтой сөрөг нөлөө үзүүлдэг. (Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь, ХЭҮТ, 2011 он.)

Гэтэл хүчирхийллийн шинж тэмдэг байсаар байтал түүнийг заавал нотлох баримтаар тогтоохыг шаардаж, шүүхээс нэг талын гаргасан гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг хүлээн авахгүй байх нь Монгол Улсын ИХШХШТХ-ийн 132.4 болон Гэр бүлийн тухай хуулийн 14.4 дэх хэсгийг тус тус зөрчсөн, эсрэгцсэн хуулийн зохицуулалт болжээ. (Сувд-Эрдэнэ, Г. Гэр бүл, хүүхдийн холбогдолтой хэргийг шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хууль тогтоомжид хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн тайлан, Хууль зүй, дотоод хэргийн яам, 2024 он)

ИХШХШТХ-ийн 132.4 ба Гэр бүлийн тухай хуулийн 14.4 дэх хэсгийн “...эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцалж болно” гэсэн зохицуулалт нь хууль зүйн хувьд хамгаалалтын заалт мэт боловч амьдрал дээр хэрэгжих түвшинд сул, нотлох баримтын шаардлага хэт өндөр байгаа нь зорилгодоо нийцэхгүй байгааг илэрхийлж байна. Иймээс гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэрлэлт цуцлах хэрэгт нотолгооны шаардлагыг хөнгөрүүлэх, эвлэрүүлэх ажиллагааг шаардлагатай тохиолдолд хасах, шуурхай шийдвэрлэх зэрэг хууль, шүүхийн реформ хийх шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд Монгол гэр бүлийн уламжлалт харилцаанд нийгэм, эдийн засаг, соёлын олон хүчин зүйлийн нөлөөгөөр мэдэгдэхүйц өөрчлөлт гарч байна. Нийгмийн үнэт зүйл, ёс суртахууны доройтол, хөдөлмөрийн зах зээлийн хүндрэл, ядуурал, төрийн бодлогын сул тал зэрэг дотоод хүчин зүйлсийн зэрэгцээ глобалчлал, соёлын өөрчлөлт зэрэг гадаад нөлөөлөл гэр бүлийн тогтолцоонд давхар дарамт үзүүлж байна. Үүний улмаас гэр бүлийн эрх зүйн харилцаанд илэрч буй сөрөг үр дагаврыг бууруулах, цаашдын чиг хандлагыг зөв тодорхойлох, урьдчилан сэргийлэх бодитой арга механизм боловсруулах шаардлага улам бүр нэмэгдэж байна. (Оюун-Эрдэнэ, Б. Эмэгтэйчүүдийн хөгжил, цэцэглэл үндэсний чуулганд зориулсан илтгэлээс.)

Мөн сүүлийн жилүүдэд гэр бүл цуцлалтад нөлөөлж байгаа нэгэн хүчин зүйл бол эмэгтэйчүүдийн санхүүгийн болон боловсролын түвшин өсөх, бие даасан байдал нэмэгдсэн явдал юм.

Орчин үеийн гэр бүлийн эрх зүйн харилцаанд “economic independence hypothesis” буюу эдийн засгийн бие даасан байдлын онол өргөн хэрэглэгддэг бөгөөд

эмэгтэйчүүдийн эдийн засгийн бие даасан байдал нь гэр бүл салалтын үйл явцыг ойлгоход чухал ач холбогдолтой. Хэдийгээр тус үзүүлэлт нь гэр бүл цуцлах эрсдэлийг мэдэгдэхүйц нэмэгдүүлж байгаа ч, салалтын түвшин огцом өсөхөд эдгээр нийгмийн өөрчлөлт шууд нөлөөлсөн эсэх нь тодорхой бус байдаг байна. (Economic Independence and Marital Dissolution: A Review. Center for Demography and Ecology Working Paper 1992-28, University of Wisconsin.) Тус онолын дагуу аваад үзэхэд:

- Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өсөх;
- Хөдөлмөрийн зах зээлд тэдний ажил эрхлэлтийн оролцоо нэмэгдэх;
- Өөрийн гэсэн тусдаа орлого бий болох;
- Нөхрөөс хамааралтай санхүүгийн хамаарал багасах зэрэг үр дагавар нь эмэгтэйчүүдийн ирээдүйд хүнтэй гэрлэх эсвэл гэрлэлтээ үргэлжлүүлэх магадлалыг тодорхой нэгэн хэмжээгээр бууруулдаг байна.

Эмэгтэй хүний орлого өсөх тусам гэр бүл цуцлалтын хувь өсөх хандлагатай буюу өндөр орлоготой эмэгтэйчүүд дундаж орлоготой эмэгтэйчүүдтэй харьцуулахад тэдний санхүүгийн болон боловсролын хараат бус, бие даасан байдал өндөр байдаг. Онолын болон судалгааны хүрээнд энэхүү үзэгдлийг аваад үзвэл, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоотойгоор гэр бүл цуцлалтын түвшин нэмэгдэж байгааг АНУ-ын эдийн засгийн судлаач нар болох Dale Bremmer, Randy Kesselring нар 2004 онд хийсэн урт хугацааны хамаарлын шинжилгээндээ онцолж авч үзжээ.

2018 оны 5 сарын 8-ны өдөр Xu Dong судлаачийн гаргасан “Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо ба салах магадлал” нэртэй судалгааны бүтээлд 1995-1997 оны хоорондох хувь хүний боловсролын болон санхүүгийн гэх зэрэг олон түвшний мэдээлэл, өгөгдлийг ашигласнаар эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо нэмэгдсэн нь гэр бүл цуцлалтын магадлалыг нэмэгдүүлэхэд хүргэж болзошгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо байхгүй гэж дүгнэжээ. Гэр бүл дэх хүүхдийн тоо нь гэр бүл цуцлах магадлалд урвуу хамаарал үзүүлдэг буюу 1 хүүхэд нэмж төрүүлэх нь гэр бүл цуцлуулах магадлалыг дунджаар 0.0289-оор бууруулж, бусад хувьсагчдыг тогтмол байлгадаг байна. (Dong, X. (2018). Women's Labor Force Participation and Probability of Getting Divorced.)

Мөн 2016 онд Мичиганы Их Сургуулийн хүн ам зүйч, социологийн профессор Alexandra Killewald өөрийн гаргасан “Мөнгө, ажил, гэр бүлийн тогтвортой байдал: Гэр бүл цуцлалтыг хүйсээр тодорхойлогч хүчин зүйлсийн өөрчлөлтийг үнэлэх нь” судалгааны бүтээлдээ 1968-2013 оны хоорондох АНУ-ын “Panel Study of Income

Dynamics” судалгаанд өгөгдсөн мэдээлэл дээр үндэслэн эхнэр, нөхөр хоёрын хөдөлмөрийн хуваарилалт, тэдний санхүүгийн эх үүсвэр, гэр бүл цуцлалтын үед эхнэр нь өөрийгөө хэрхэн тэжээх чадвар нь гэр бүл цуцлалтын үед гарах эрсдэлтэй хэрхэн холбогдож, өөрчлөгдсөнийг авч үзсэн байна. Түүний гаргасан дүгнэлт нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн бие даасан байдал нь гэр бүл цуцлалтад шууд нөлөөлдөггүй болохыг тогтоожээ. (Killewald, A. (2016). Money, Work, and Marital Stability: Assessing Change in the Gendered Determinants of Divorce: Assessing Change in the Gendered Determinants of Divorce. American Sociological Review, 81(4), 696-719. <https://doi.org/10.1177/0003122416655340>)

Дүгнээд үзэхэд, эдгээр судалгааны бүтээлүүдэд хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийн ажиллах хүчин, тэдний эзлэх хувь, санхүүгийн болоод боловсролын хараат бус байдал нь гэр бүл цуцлалтад тодорхой нэгэн хэмжээгээр нөлөө үзүүлдэг байна. Гарч буй ялгаатай дүн нь судлаачдын ашигласан арга зүй, тэр үеийн нийгэм-эдийн засгийн байдал, үнэт зүйлийн шилжилт, соёлын ялгаа зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байх магадлалтай. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдийн олох орлого, ололт, амжилт ба гэр бүл цуцлалтын хамаарал нь цаг үе, нийгмийн тогтолцоо, гэр бүлийн эрх, үүргийн хуваарилалт, тэдгээрийг судалсан судалгааны арга зүйгээс хамаарсан тогтвортой бус “хувьсамтгай” үзэгдэл болохыг дээрх судалгаануудын харьцуулсан дүнгээс харж болно.

Хүснэгт 2.2 Гэр бүл цуцлалтад нөлөөлөгч нийгмийн болон сэтгэл зүйн хүчин зүйлс

№	Нийгмийн хүчин зүйлс		Сэтгэл зүйн хүчин зүйлс	
1.	Цаг үеэ дагасан нийгмийн өөрчлөлт ба үнэт зүйлийн шилжилт	Хувь хүний эрх, бие даасан байдлыг чухалчлах хандлага нэмэгдэж, уламжлалт гэр бүлийн тогтвортой байдал суларч байна.	Хоорондын харилцааны ур чадвар ба сэтгэл зүй	Үл ойлголцол, итгэл алдагдах, уур бухимдал хуримтлагдах нь харилцааг эвддэг.
2.	Эдийн засгийн хүчин зүйл	Орлогын ялгаа, санхүүгийн тогтворгүй байдал, ажилгүйдэл, өр зээл нь гэр бүлийн маргааны эх үүсвэр болдог.	Таарамжгүй байдал ба зан чанарын ялгаа	Сэтгэл зүйн төлөвшил дутмаг, зан араншингийн зөрүү хамтын амьдралд сөрөг нөлөөтэй.
3.	Боловсрол ба соёлын түвшний ялгаа	Үнэт зүйл, амьдралын хэв маяг, итгэл үнэмшлийн зөрүү гэр бүлийн харилцаанд	Гэр бүлийн хүчирхийлэл, сэтгэл санаагаар дарамтлах	Сэтгэл санааны дарамт, бие махбодийн хүчирхийлэл

		зөрчил үүсгэдэг.		салалтын гол шалтгаан болдог.
4.	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, технологийн нөлөө	Олон нийтийн сүлжээ, холын зайн харилцаа нь итгэлцлийг алдагдуулах эрсдэлтэй.	Сэтгэл ханамж ба түүнээс авах таашаал	Хайр халамж, харилцан ойлголцол багассанаар салалтын шийдвэрт хүрдэг.
5.	Хууль эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт	Гэр бүл цуцлах журам, шүүхийн практик, тэтгэмжийн зохицуулалт хосуудын шийдвэрт нөлөөлдөг.	Стресс ба хариуцлага	Ажил, гэр бүл, хүүхдийн өмнөх хариуцлага сэтгэл зүйн дарамт үүсгэдэг.

Гэр бүл цуцлалтыг сэтгэл зүйн хүчин зүйл талаас нь авч үзвэл гэр бүлээ цуцлуулах эрсдэлийг бууруулах 10 зөвлөмж байдаг. Эдгээр нь:

- Хамгийн багадаа 20 нас хүрсний дараа гэрлэх; 25 настайдаа гэрлэхээр бол бүр илүү тохиромжтой.
- Гэрлэлтийн өмнөх жирэмслэлтээс сэргийлэх, мөн зөвхөн жирэмсэн болсны улмаас гэрлэхээс зайлсхийх.
- Гэр бүлийн харилцаагаа тогтвортой хадгалж үлдэхийн тулд идэвх санаачлагатай байх (ном унших, сургалт, хосын зөвлөгөө авах, сэтгэл зүйч дээр тогтмол очих гэх мэт).
- Хамтран амьдрахын эрсдэлийг ойлгох, хүлээн зөвшөөрөх (хамтран амьдрах $\neq$ гэр бүл тогтвортой байх баталгаа биш).
- Гэрлэсний дараа гэрлэлтээс гадуурх харилцаа хайхгүй байх, өөр сайн хүн олох бодлоос татгалзах.
- Гэрлэгчид бие биедээ уян хатан байж, аль алиныхаа сул талуудыг эв зүйгээр зохицуулах арга олох.
- Ямарваа нэгэн асуудал гарсан тохиолдолд өөдрөг хандлагатай байж, ойр зуурын бэрхшээлд хэт анхаарал төвлөрүүлэхгүйгээр, ирээдүйгээ төлөвлөх.
- Хань ижлээ сонгохдоо хангалттай хугацаа зарцуулах; яаран гэрлэхээс зайлсхийх.
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээнд гарч буй мэдээлэл, тохиолдол бүрийг өөрийн амьдралтай хэт их холбон, ургуулан бодохгүй байх.
- Өөрийн гэсэн гэр бүлтэй байх давуу тал, ашиг тусыг харгалзан үзэх, сөрөг тал дээр хэт төвлөрөхөөс зайлсхийх зэрэг болно.

<https://courses.lumenlearning.com/atd-herkimer-marriageandfamily/chapter/14-divorce/>

2.2 Гэр бүл цуцлалтын шалтгаан, харьцуулсан судалгаа

Гэр бүл цуцлалт нь зөвхөн хууль зүйн үйл явц биш, нийгмийн бүтцэд шууд нөлөө үзүүлдэг үзэгдэл юм. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад хотжилт, санхүүгийн дарамт, ажилгүйдэл, соёлын өөрчлөлт, харилцааны зөрчил, сэтгэл зүйн уур амьсгал зэрэг хүчин зүйлс салалтын тоог нэмэгдүүлж байна. Нийгмийн орчин өөрчлөгдөхийн хэрээр гэрлэлтийн талаарх хандлага эрх чөлөөтэй болж, хувь хүний эрх, эрх чөлөөг илүүд үзэх хандлага өсөн нэмэгдсэн нь гэр бүл цуцлалт ихсэхэд нөлөөлдөг. Энэ үзэгдэл нь хууль тогтоомжийн уялдаа, бодлогын чиглэлд тодорхой сорилт авчирч байна.

1960-1980-аад оны үед гэр бүл судлал, гэр бүл цуцлалтын нийгмийн болон сэтгэл зүйн хүчин зүйлсийг судалсан Америкийн гэр бүл судлаач Reva S. Wiseman 1975 онд гаргасан үндсэн өгүүлэлдээ дэвшүүлсэн онолын хүрээнд гэр бүл цуцлалтыг “гэрлэгчид сэтгэл санааны хямралд орсноор эхэлдэг үйл явц бөгөөд энэ нь гэр бүлийн зөрчилдөөнийг дуусгавар болгох замаар шийдвэрлэх оролдлого, өөр өөр үүрэг, амьдралын хэв маягтай шинэ байр сууринд орох замаар төгсдөг” гэж тайлбарласан байдаг.

(Comparison of Predisposing and Effective Factors on Divorce Application between Men and Women, WHO, Vol. 6, No. 2, June 2012)

Гэр бүл салалтад хийсэн социологийн шинжилгээнд дурдсанаар гэр бүл салалтад хүргэдэг түгээмэл шалтгаануудад гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлээс гадуурх бэлгийн харьцаа, архидалт, үзэл санааны зөрчилдөөн гэх мэт асуудлууд дээгүүр байр суурь эзэлдэг байна. Мөн санхүүгийн хүнд нөхцөл, гэр бүлийн дотоод асуудал дахь хадмуудын хэт их оролцоо, дутуу хайр халамж, эрүүл мэндийн шалтгаан зэрэг нь салах шийдвэр гаргахад түлхэц болдог гол хүчин зүйлс болох нь судалгаанд тэмдэглэгджээ. (Бүрэнжаргал, Т. Гэр бүл салалтад хийсэн социологийн шинжилгээ, 2022 он)

Хүснэгт 2.3 Гэрлэлт цуцлалтын үндэслэл, 2021-2023 оны байдлаар

Шалтгаан	2021 он	2022 он	2023 он	Нийт
Албан ажил мэргэжил нөлөөлсөн	7	14	28	49
Архины хамааралтай	150	196	166	512
Бусад	474	603	630	1707

Гэр бүлийн хувьд тогтвортой бус	154	249	311	714
Зан харьцаа таарахгүй	2520	3431	3584	9535
Сураггүй алга болсон	2	4	5	11
Тодорхой бус	37	2	5	44
Хадамтайгаа таарамжгүй	5	13	7	25
Хорих газарт ял эдэлдэг	7	8	10	25
Үр хүүхэдгүй	31	26	22	79
Эр эмийн харьцаа таардаггүй	16	11	15	42
Нийтдээ	3403	4557	4783	12743

Эх сурвалж: УБЕГ-ын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 3/1650 дугаар албан бичиг.

Манай улсын хувьд 2021-2023 оны хооронд гэрлэлт цуцлалт жил дараалан өссөн бөгөөд нийтдээ 12743 гэрлэлт цуцлагдсан нь 2021 онтой харьцуулахад 28.8%-иар өссөн үзүүлэлт гарчээ. Тэдгээрийн 9535 гаруй нь “зан харьцаа таарамжгүй” гэх шалтгаан эзэлж байгаа нь нийт гэр бүл цуцлалтын 75 гаруй хувийг буюу хамгийн их хувийг эзэлжээ. Гэвч зан харьцаа таарахгүй, гэр бүлийн тогтворгүй байдал болон бусад ерөнхий шалтгааныг дурдан гэрлэлт цуцалж буй эдгээр тохиолдлын ард ямархуу бодит нөхцөл байдал, гүнзгий асуудлууд оршиж байгааг илэрхийлэх нарийвчилсан судалгаа, мэдээлэл хангалтгүй хэвээр байна.


Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар “зан харьцаа таарахгүй” хэмээн тодорхойлогдож буй шалтгааны сууринд гэр бүлийн хүрээнд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хамтын хариуцлагын талаарх хосуудын ойлголт, хандлагын ялгаа, гэр бүл дэх эрх мэдлийн тэнцвэрт бус байдал, хүйсийн тэгш байдал болон гэр бүлийн харилцааны талаарх мэдлэг, ойлголт дутмаг байдал нөлөөлсөн байх магадлалтай. Үүний улмаас үл ойлголцол, маргаан, зөрчил хурцдаж, эцэстээ гэр бүл салалтад хүрч байгаа гэж дүгнэж байна.

АНУ-д гэрлэлтээ цуцлуулсан эсвэл цуцлуулах гэж буй 1000 гаруй хүмүүсийг хамруулсан судалгаа явуулсан бөгөөд тус улсад 2021 оны байдлаар нийтдээ 689,308 гэр бүл цуцлалтын тохиолдол бүртгэгдсэн бөгөөд хосууд гэр бүлээ цуцлуулахдаа шүүхэд тодорхой “Гэр бүл цуцлах үндэслэл” (grounds for divorce) гаргах шаардлагатай байдаг.

Ихэнх хосууд “no-fault divorce” буюу тодорхой буруутай этгээдгүйгээр гэрлэлтээ цуцлуулах хэлбэрийг сонгодог. Үүнд ихэвчлэн “зөрчилдөөнийг даван туулах боломжгүйн ялгаатай байдал” (irreconcilable differences) хэмээх шалтгааныг дурддаг. Судалгаагаар гэрлэлтээ цуцлуулсан хүмүүсийн 31% нь хоорондоо нийцэхгүй байдал, таарч тохирохгүй зан чанар зэргээс шалтгаалсан гэжээ.

Гэсэн хэдий ч “зүгээр л ойлголцохгүй байх” нь түгээмэл шалтгаан болж байвч, бие биедээ үнэнч бус байх байдал буюу хууран мэхлэлт, араар тавилт нь илүү ноцтой асуудал хэвээр байна. Судалгаанд хамрагдсан хосуудын 34% нь гэр бүлээ гуравдагч этгээдтэй гэр бүлээс гадуурх харилцаа тогтоосон буюу араар тавьсан гэх шалтгаанаар цуцлуулжээ. Шүүхийн практикт, энэ нь “fault divorce” буюу нэг тал буруутайгаар цуцлах үндэслэл болдог хэдий ч зарим тохиолдолд хосууд илүү хялбар гэж үздэг тул “no-fault divorce” хэлбэрийг сонгодог байна.

Зураг 2.4 АНУ-ын гэр бүл салалтад хүргэдэг гол шалтгаанууд



Хүмүүс тодорхой зорилгын хүрээнд гэрлэх тохиолдолд, хэрэв тэр зорилго нь хангагдахгүй бол гэрлэлтээ цуцлуулах эрсдэл нэмэгддэг. Иймд хүнтэй гэрлэх шалтгаан ба гэр бүл цуцлах шалтгаануудын хооронд тодорхой хамаарал байгааг ажиглах нь зүйтэй. Ихэнх хосууд хамтдаа амьдрах хүсэл, санхүүгийн баталгаа, хоорондын нийцтэй байдал, хууль эрх зүйн шалтгаан, эсвэл гэр бүл зохиох, хүүхэдтэй болох хүсэл зэргээс үүдэн гэрлэсэн байдаг. Гэвч эдгээр бүлгийн хосуудын дийлэнх нь таарч тохирохгүй байснаас үүдэн гэр бүлээ цуцлуулдаг нь батлагджээ. Мөн хайр сэтгэлээрээ биш харин нийгмийн болон гэр бүлээс ирэх дарамт, ирээдүйгээ баталгаатай байлгах үүднээс гэрлэсэн хүмүүс илүү өндөр хувьтайгаар гэрлэлтээс гадуурх харилцаанаас буюу араар тавилтаас болж гэрлэлтээ цуцлуулсан нь тогтоогджээ.

Хүснэгт 2.4 Шүүхэд гэр бүл цуцлуулах өргөдөл өгсөн үндэслэл

2010 онд хийгдсэн судалгааны үр дүн	2017 онд хийгдсэн судалгааны үр дүн
Үзэл санааны зөрчилдөөн (26,3%)	Тус, тусдаа амьдардаг (43%)
Архины хэрэглээ (22,5%)	Хоорондоо нийцэхгүй байдал, үзэл санааны зөрчил, хэрүүл (41,6%)
Гэр бүлээс гадуур бэлгийн харьцаа (20%)	Гэр бүлээс гадуур бэлгийн харьцаа (25,9%)
Соёл, боловсролын түвшний ялгаа (8,8%)	Хүчирхийлэл (23,4%)
Дундаасаа үр хүүхэдгүй (7,5%)	Архины хамаарал (23,3%)
Гэр бүлээс ирэх дарамт, шахалт (5%)	Өөр, өөр гэр бүлтэй болсон гэх (20,4%)
Амьдралын түвшин, бололцоо ялгаатай байдал	Сэтгэл санаагаар дарамталдаг (13,5%)
Хадам эцэг, эхээс ирэх дарамт (3,8%)	Холын зайн харилцаатай, уулзах нь ховор (8%)
Холын тээвэрт ихэвчлэн явдаг (1,3%)	Үгээр дарамталдаг (6,2%)
	Бусад гэр бүлийн гишүүдээс ирэх сөрөг дарамт, шахалт (5,2%)

Эх сурвалж: “Good Neighbors” олон улсын байгууллагаас хийсэн “Гэр бүлийн маргаан болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй мэргэжилтнүүдийг чадавхижуулах төсөл”-ийн хүрээнд эвлэрүүлэн зуучлагч нараас авсан судалгааны үр дүн.

Статистик мэдээллээс харахад гэр бүл цуцлах гол шалтгаанууд нь архины хамаарал, гэр бүлийн таарамжгүй харилцаа, тогтмол хэрүүл маргаан, үзэл бодлын зөрчил, гэр бүлээс гадуурх харилцаа, сэтгэл санааны болон бие махбодын хүчирхийлэл зэрэг байна.

Судалгаанд 7 жилийн интервалтай харьцуулсан үзүүлэлтүүдийг ашигласнаар гэр бүлийн орчны өөрчлөлтийг тодорхой харуулах боломжтой болжээ. Тухайлбал, 2010 онд гэр бүл цуцлах шалтгаануудын дийлэнх хувийг “үзэл бодол нийлэхгүй байх, архины хамаарал болон гэр бүлээс гадуурх харилцаа” эзэлж, нийтдээ ойролцоогоор 70 орчим хувь болсон байна. Харин 2017 он гэхэд “таарамжгүй харилцаа болон тусдаа амьдрах болсон” шалтгаан давамгайлж, нийт шалтгааны 80 гаруй хувийг бүрдүүлэх болжээ. Мөн 2010 онд гэр бүл цуцлалтын 4 орчим хувийг “хадам эцэг, эхийн нөлөө” эзэлж байсан бол 2017 онд энэ үзүүлэлт 5.2 хувь болж өссөн нь гэр бүлийн харилцаанд гэр бүлийн бусад гишүүдийн оролцоо нөлөөлсөөр байгааг харуулж байна.

Монгол улсын Гэр бүлийн тухай хууль шинэчлэгдэн найруулагдаж байгаатай холбогдуулан 1999 онд батлагдсан хуулийн зүйл, заалтыг шинэчлэн найруулагдах гэж буй хуулийн төслийн гэр бүл цуцлалттай холбоотой зүйл, заалттай харьцуулж үзвэл үүнд Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулах төсөлд гэр бүл цуцлалтын

харилцааг өмнөх зохицуулалтаас илүү нарийвчлан, хүний эрх, эрх чөлөө, хүүхдийн эрх, ашигт суурилсан байдлаар зохицуулах оролдлого тодорхой ажиглагдаж байна. Ялангуяа гэрлэлт цуцлах ажиллагаанд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаалах, шүүхийн үнэлэмжийг бодит нөхцөл байдалд нийцүүлэн хязгаарлах, эмзэг бүлгийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх зохицуулалтууд нь эрх зүйн бодлогын томоохон ахиц дэвшил гэж үнэлэх боломжтой.

Хүснэгт 2.5 МУ-ын одоогийн болон шинэчлэн найруулсан Гэр бүлийн тухай хуулийн төслийн харьцуулалт

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хууль	Шинэчилсэн Гэр бүлийн тухай хуулийн төсөл	Тайлбар	Шинэчлэгдэн нэмэгдсэн хуулийн зүйл заалт
Гэрлэлт дуусгавар болох үндэслэлийг нас барсан, гэрлэлт цуцалсан, хүчин төгөлдөр бус гэж тооцсон гэсэн ерөнхий байдлаар зохицуулсан. (11 дүгээр зүйл)	Гэрлэлт дуусгавар болох үндэслэлийг нарийвчлан ангилж, сураггүй алга болсон, хүйсийн өөрчлөлтийг бүртгүүлсэн зэрэг шинэ нөхцөлийг тусгасан. (10 дугаар зүйл)	Шинэчилсэн төсөл нь гэрлэлт дуусгавар болох нөхцөлийг бодит амьдралын өөрчлөлттэй уялдуулан өргөтгөж, илүү тодорхой болгосон.	10.1.2.гэрлэгчдийн хэн нэг нь сураггүй алга болсон гэж тооцогдсон; 10.1.3.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө иргэний улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн.
Гэрлэлтийг захиргааны болон шүүхийн журмаар цуцална гэж ерөнхийлөн заасан. (12 дугаар зүйл)	Гэрлэлт цуцлах ойлголтыг бие даасан зүйл болгон тодорхойлж, хүүхдийн эрх, асрамж, тэтгэмжийн асуудлыг салангид байдлаар нарийвчлан зохицуулсан. (11, 13 дугаар зүйл)	Гэрлэлт цуцлахтай холбоотой эрх зүйн харилцааг системтэй, цогцоор нь зохицуулсан нь шинэлэг зохицуулалт юм.	11.2.Гэрлэлт цуцлуулсан нь хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, асран хамгаалах эцэг, эхийн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
Шүүхийн журмаар цуцлах үндэслэлийг	Шүүх гэрлэлт цуцлахдаа харгалзан үзэх	Материаллаг болон процессын	13.2.Энэ хуулийн 10.1.3-т заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн

нарийвчлан заагаагүй, процессын журамд түлхүү анхаарсан. (14 дүгээр зүйл)	шалгуур үзүүлэлт, хүүхдийн эрхийг хамгаалах зарчмыг дэлгэрэнгүй заасан. (13 дугаар зүйл)	шалгуурыг хослуулан, хүүхдийн эрхийг нэн тэргүүнд хамгаалсан зохицуулалт болсон.	өөрчлөлтөө иргэний улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, гэрлэлт дуусгавар болсон бол гэрлэлт цуцлахаас бусад хүүхдийн асрамж, тэтгэлэг, дундын эд хөрөнгө хуваах асуудлыг нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ. • 13.4.Шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа тэргүүн ээлжид хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл хөдөлмөрийн чадваргүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзнэ. • 13.10.Шүүх гэрлэлт цуцлахдаа нэхэмжлэлийн шаардлагаас үл хамааран дараах асуудлыг шийдвэрлэнэ: 13.10.1.хүүхдийн асрамж; 13.10.2.тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах эрх, үүрэг, уулзах хугацаа, байршил, нөхцөл; 13.10.3.тэтгэмжийн хэмжээ, нэмэлт зардал, сургалтын төлбөрийг хариуцах асуудал. • 13.12.Эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн
--	---	---	---

			захиргааны байгууллагаас мэргэжил, арга зүйн дэмжлэг авч, хамтран ажиллаж болно.
Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг заавал хэрэгжүүлэх хандлагатай байсан. (14.2)	Тодорхой нөхцөлд эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцлах боломжийг өргөтгөсөн. (14 дүгээр зүйл)	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах эрх зүйн баталгааг нэмэгдүүлсэн.	14 дүгээр зүйл.Шүүхээс гэрлэлт цуцлах тусгай журам 14.1. Шүүх дараах тохиолдолд эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцалж болно: 14.1.1.гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон; 14.1.2.гэрлэгчид сүүлийн таваас доошгүй жилийн хугацаанд хамтран амьдраагүй бөгөөд бага насны хүүхэдгүй, гэрлэлт цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн; 14.1.3.эд хөрөнгийн маргаантай боловч 18-аас доош насны хүүхэдгүй гэрлэгчид гэрлэлт цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн.
Хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ хүүхдийн саналыг харгалзах тухай ерөнхий заалттай байсан. (14.7)	Хүүхдийн саналыг мэргэжлийн шинжээчээр дамжуулан авах, асрамжийн хэлбэрийг дангаар болон хамтран хэрэгжүүлэхээр зохицуулсан. (13.5–13.9)	Хүүхдийн эрхийн олон улсын стандартад нийцсэн, илүү нарийвчилсан зохицуулалт болсон.	• 13.6.Энэ хуулийн 13.5-д заасны дагуу хүүхдийн саналыг авахдаа гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчээр дамжуулан авна. • 13.17.Энэ хуулийн 13.10.2-т заасан тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хугацааг тогтоохдоо хүүхдийн нас, эцэг, эхийн ажлын ачаалал, хүүхдийн сонирхлыг харгалзан

			үзнэ.
Хүндээр өвчилсөн эхнэр, нөхрийн зөвшөөрөлгүйгээр гэрлэлт цуцлахыг хориглосон. (12.2)	Хориглох нөхцөлийг хэвээр үлдээсэн боловч жирэмсэн эхнэр, бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг илүү өргөн хүрээнд хамгаалсан. (13.13–13.15)	Нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах хүрээ өргөжсөн.	13.13.Гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвчилсөн тохиолдолд хүндээр өвчилсөн гэрлэгч гэрлэлтээ цуцлуулахыг зөвшөөрөөгүй бол гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзана. 13.14.Эхнэр нь жирэмсэн, эсхүл гурван насанд хүрээгүй хүүхэдтэй, эсхүл хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд эхнэр нь гэрлэлтээ цуцлуулахыг зөвшөөрөөгүй бол гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзана.

Эх сурвалж: Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/

Монгол Улсын өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэр бүлийн тухай хуулийн зарим сул талын хувьд гэрлэлт цуцлах тодорхой материаллаг үндэслэл буюу “удаан хугацаанд тусдаа амьдрах, хүчирхийлэл, гэрлэгчдийн харилцааны бүрэн дуусгавар болголт” зэрэг үндэслэл шууд нэрлэгдээгүй, харин гэрлэгчдийн хэн нэгний нэхэмжлэл болон эвлэрэх боломжгүй болсон эсэх, захиргааны журмаар шийдвэрлэхээс бусад гэсэн ерөнхий, тодорхой бус зохицуулалтаар шүүхийн журмаар цуцлах асуудлыг шийдвэрлэж ирсэн явдал билээ. Үүний үр дүнд шүүх бүр өөрийн үзэмжээр шийдвэр гаргах, нэг төрлийн гэр бүлийн холбогдолтой маргаанд өөр өөр шийдвэр гарах, гэр бүл цуцлах үндэслэл нь хуульд бус, харин практик дээр тогтдог байдал бий болсон.

Шинэчилсэн хуулийн төсөлд орсон эерэг өөрчлөлтийн хувьд аваад үзвэл үүнд:

- Гэрлэлт дуусгавар болох ойлголт;
- Хүйсийн өөрчлөлт гэх нэршил болон ижил хүйстний гэрлэлтийг хуулиар хориглох;
- Эвлэрүүлэхгүйгээр цуцлах онцгой нөхцөлүүдийг шүүхээс гэрлэлт цуцлах тусгай журам гэсэн хэлбэрээр тодорхой, ангилалтайгаар зохицуулснаараа онцлогтой.


Тухайлбал, гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, удаан хугацааны турш тусдаа амьдарсан байдал, эвлэрэх бодит боломжгүй нөхцөл байдал зэргийг шүүхээс эвлэрүүлэхгүйгээр гэрлэлт цуцлах үндэслэл болгож заасан нь гадаадын улс орнуудын (Япон, БНСУ, ХБНГУ) эрх зүйн жишигт нэгэн алхмаар ойртсон явдал юм.

Монгол Улсын шинэчилсэн Гэр бүлийн тухай хуулийн төслийн давуу талууд нь хүүхдийн эрхийг нэн тэргүүнд тавих буюу олон улсад хэрэглэгддэг “Best of Interest”-ийг хэрэгжүүлэх, гэрлэгчдийг эвлэрүүлэхгүйгээр цуцлах нөхцөлийг тодорхойлж шүүхийн оролцоог нарийсгасан зэрэг болсон. Гэхдээ үүнд гэр бүл цуцлах материаллаг үндэслэлийг хуульд нарийвчлан зохицуулж өгөөгүй хэвээр байгаа, мөн эдийн засгийн болон сэтгэл санааны хүчирхийллийг хэрхэн нотлох зэргийг тодорхойлон хуульчлаагүй байгаа нь нэгэн сул тал хэвээрээ байгаа юм.

2.3 Шүүхийн шийдвэр

Монгол Улсад гэр бүл цуцлах тухай асуудлыг шийдвэрлэх эрхийг зөвхөн шүүх хэрэгжүүлдэг бөгөөд шүүх нь гэрлэлт цуцлах үндэслэл, талуудын гэр бүлийн харилцааны шинж чанар, хүүхдийн эрх ашиг, эд хөрөнгийн эрхийн хуваарилалтыг иж бүрнээр харгалзан үздэг. Гэр бүлийн холбогдолтой хэргийг иргэний шүүх дангаар шийддэг бөгөөд шүүхийн шийдвэрийн цахим санд дурдагдсан тайлан мэдээнээс харвал 2020 оны байдлаар 53678, 2021 оны эхний хагас жилд 20602 иргэний хэрэг, маргаан шийдвэрлэснээс Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн үзүүлэлт нь 2020 онд 4732, 2021 оны эхний хагаст 2085 байжээ. Энэ нь тооцоод үзвэл нийт иргэний хэргийн 10.1%-г эзэлсэн байдалтай байгаа юм. (Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн тайлан. УБ., 2020. 2021 оны эхний хагас жил.)

Зураг 2.5 Гэр бүлийн хэргийн иргэний хэрэгт эзлэх хувь (2020-2021 оны байдлаар)



Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн тайлан. УБ., 2020. 2021 оны эхний хагас жил.

Гэр бүл цуцлах тухай маргаан нь Иргэний хуулийн Гэр бүлийн хөрөнгийн эрхийн зохицуулалт, Гэр бүлийн тухай хуулийн холбогдох заалтуудад үндэслэн

шийдвэрлэгддэг бөгөөд шүүх нь гэр бүлийн эрх зүйн харилцаа бүрэн дуусгавар болох, эвлэрүүлэн зуучлал амжилттай явагдсан эсэх, мөн хүүхдийн эрх ашиг, эд хөрөнгийн хуваарилалтыг харгалзан үздэг.

Хүснэгт 2.6 Гэрлэлт цуцлалтын бүртгэл

Гэрлэлт цуцлалтын төрөл	2021 он	2022 он	2023 он	Нийт
Захиргааны журмаар	1107	1484	1448	4039
Шүүхийн шийдвэрээр	2296	3073	3335	8704
Нийт	3403	4557	4783	12743

Эх сурвалж: УБЕГ-ын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 3/1650 дугаар албан бичиг.

2021-2023 оны хугацаанд нийт 12,743 гэрлэлт цуцлагдсанаас 4,039 нь захиргааны журмаар, 8,704 нь шүүхийн шийдвэрээр шийдвэрлэгдсэн байна. Шүүхийн журмаар цуцлагдсан гэрлэлтийн тоо нь захиргааны журмаар цуцлагдсантай харьцуулахад 2.1 дахин их байгаа нь гэр бүл цуцлах асуудалд шүүхийн оролцоо давамгайлж буйг илтгэнэ. Үзүүлэлтийг жилээр авч үзвэл, 2021-2022 онд гэрлэлт цуцлалтын тоо 777-оор, харин 2022-2023 онд 262-оор нэмэгдсэн нь сүүлийн жилүүдэд гэр бүл цуцлалтын түвшин тогтмол өсөх хандлагатай байгааг харуулж байна.

Гэр бүл салалтын тоо жилээс жилд өсөж байгаа нь зөвхөн гэр бүлийн гишүүдийн харилцаанд төдийгүй хүүхдийн хууль ёсны эрх ашиг, хүмүүжилд сөргөөр нөлөөлж, нийгмийн хэмжээнд олон талын таагүй үр дагаврыг үүсгэж байна. Сүүлийн гурван жилийн хугацаанд нийт 9,368 гэрлэлт цуцлагдсанаас 4,233 хэрэгт эцэг, эхийн хүүхдээ тэжээн тэтгэх үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 6,187 хүүхдэд тэтгэлэг тогтоосон нь гэр бүл цуцлалтын хамгийн эмзэг, хохирч буй бүлэг нь хүүхдүүд байгааг илтгэж байна. Эдгээр үзүүлэлтээс харахад Монгол Улсад ойролцоогоор 4 гэр бүл тутмын 1 нь гэр бүлээ цуцлуулж байгаа нь гэр бүл дэх тогтвортой байдал алдагдаж буй ноцтой нөхцөл байдлыг харуулж байна.

Хүний эрхийн үндэсний комиссын явуулсан судалгаагаар иргэдийн гэр бүл цуцлалтын талаарх үзэл хандлагыг тодруулахад оролцогчдын 41.7% нь “үзэл санаа нийлэхгүй бол салж болно” гэж үзсэн бол 38.4% нь “нэгэнт гэр бүл бололцсон бол хамтын амьдралаа үргэлжлүүлэх ёстой” гэсэн байр суурь илэрхийлжээ. Түүнчлэн 31.7% нь “гэрлэлт бол сайн дурын харилцаа” хэмээн үзсэн бол 28.4% нь “үр хүүхдийнхээ төлөө өөрсдийн хүсэл сонирхлыг өөрчлөх шаардлагатай” гэж хариулсан нь орчин

үеийн гэр бүл болж буй хүмүүсийн үнэт зүйл, хандлага болон гэр бүлийн боловсролын ялгаатай байдлыг илтгэж байна.

Иймд гэр бүл тогтворгүй болоход нөлөөлж буй шалтгаан, нөхцөлийг гүнзгийрүүлэн судалж, суурь хүчин зүйлсийг арилгахад чиглэсэн бодлогын болон практик арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ гэр бүл цуцлахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг оновчтой, үр дүнтэй болгох шаардлага тулгарч байна. Үүний хүрээнд хүүхдэд ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрөөр, гэр бүл болохоос өмнө иргэдэд гэр бүлийн гишүүдийн хариуцлага, эрх, үүрэг, тэдний гэр бүл төлөвлөлт, тэгш эрх, хүүхдийн эрх, ашиг сонирхлын хамгаалал, хүүхдийн хүмүүжил, эцэг эх болон асран хамгаалагчийн үүрэг хариуцлагын талаарх мэдлэг, ойлголтыг тохирсон аргачлал, арга зүйгээр тасралтгүй олгох нь зүйтэй.

Гэр бүл болсон хойно гэр бүлийн гишүүдэд амьдралын үе шат, гэр бүлийн бүтэц, хэв шинжид тохирсон мэдлэг, ойлголтыг тогтмол олгож байх нь чухал бөгөөд үүнийг гэр бүлийн боловсролын давтан хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний зэрэгцээ гэр бүлд чиглэсэн дэмжлэг, үйлчилгээ, тэр дундаа сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг өргөн хүрээнд, хүртээмжтэй байдлаар зохион байгуулахад төрийн бодлогоор тэргүүн ээлжинд анхаарах нь зүйтэй. Ийм арга хэмжээ нь гэр бүлийн дотоод маргаан, үл ойлголцол, зөрчлийг бууруулах, улмаар гэр бүл салалтын эрсдэлийг багасгах, нийгэмд хариуцлагатай, тогтвортой гэр бүлийн тоог нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

Тиймээс ч үүний хүрээнд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 5.4-т “Гэрлэхийг хүсэгчдийн хэн нэг нь анх удаа гэрлэж байгаа бол гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдах бөгөөд сургалтын агуулга, сургалтад хамруулах журмыг гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан нь иргэдийн гэр бүлийн талаарх ойлголт, мэдлэгийг ахисан түвшинд авчиран, мөн энэ нь олон улсын буюу Сингапур болон ХБНГУ-ын жишигт нийцсэн бөгөөд гэрлэлтээс үүдэх маргаан, салалтыг дараа нь шийдэх бус, түүнээс өмнө урьдчилан сэргийлэх чиг хандлагыг илэрхийлж байна гэж үзэж байна.

Мөн гэр бүл цуцлах ажиллагааны үеэр шүүх хүүхдийн эрх ашгийг хамгаалахад гол анхаарлаа хандуулах ёстой боловч бодит амьдрал дээр хүүхдийн сэтгэл зүйн байдал, асрамжийн орчны чанар, тэтгэлгийн бодит хэрэгжилт хангалтгүй байдаг асуудал байсаар байна. Монгол Улсын гэр бүл цуцлахтай холбоотой тулгамдсан асуудлуудын хүрээнд дараах асуудлууд илэрдэг. Үүнд:

- Үндэслэл тодорхойгүйгээс үүдсэн шүүхийн практикийн зөрүү

Жишээлбэл, “хоорондын таарамжгүй харилцаа” гэх гэрлэлт цуцлах болсон шалтгаан нь нэг шүүхэд хангалттай, нөгөөд нь хангалтгүй гэж үзэгддэг явдал байдаг. Үүний үр дүнд шүүх гэр бүл цуцлах үндэслэлийг өөр өөрөөр тайлбарлаж, шүүгчийн үзэмж илүүтэйгээр давамгайлж байна.

- Эвлэрүүлэн зуучлалын үр нөлөө сул байдал

Шүүхийн статистик баримтаас дурдвал эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа ихэнх тохиолдолд үр дүнтэй явагддаггүй байна. Тухайн тогтолцоо нь гэрлэлтээ аврах, хоорондын асуудлаа ярилцаж ойлгох бус гэрлэгчдэд энэ нь шүүхийн процедурын “хүлээлтийн хугацаа” болж хувирсан талтай. Эвлэрүүлэн зуучлал нь гэр бүл цуцлалтаас сэргийлэх бодит хэрэгсэл биш, харин шүүхийн процессыг удаашруулагч шат болон хэрэгжиж байна.

- Хүчирхийллийн нөхцөлд нэг мөр хамгаалалт сул

Хуульд зааснаар гэр бүлийн маргаанд хүчирхийлэл байгаа гэж үзсэн тохиолдолд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулахгүйгээр гэрлэлтийг цуцалдаг боловч практикт ихэнхдээ гардаг тохиолдол нь бие махбодийнхоос бусад төрлийн хүчирхийллийг “хангалттай нотлогдоогүй” гэх шалтгаанаар эвлэрүүлэн зуучлалд оруулан гэрлэлт цуцлах хугацааг сунгах эрсдэл үүсдэг. Үүний үр дүнд ихэнхдээ хүүхэд, эмэгтэйчүүд хохирдог.

- Хүүхдийн эрхийг хамгаалах механизм хангалтгүй


Гэрлэлт цуцлах шүүхийн үйл явцын хүрээнд хүүхдийн эрх, ашиг сонирхол хамгийн түрүүнд нэн тэргүүнд тавигдах ёстой байдаг. Эцэг, эх нь салж байгаа тохиолдолд хүүхдийг хэний асрамжинд үлдээх, хүүхдийн тэтгэлгийн хэмжээ тогтоох, гэр бүл цуцлах явцад томчуудын маргаан давамгайлж, хүүхдийн эрх хоёрдугаарт тавигдах эрсдэл зэрэг асуудал үүсдэг. Шүүхээс тухайн үйл ажиллагааг явуулахдаа хүүхдээс хэнтэй нь үлдэх талаар саналыг нь авч, харгалзан үздэг бөгөөд хүүхдийг 7 нас хүрсэн байхыг шаарддаг. Одоогийн шүүхийн практикт сэтгэл зүйч, шинжээчийн оролцоо хангалтгүй байгаа нь ажиглагддаг. Харин шинэчлэн боловсруулагдаж буй Гэр бүлийн тухай хуулийн төсөлд шүүх хэрэг хянан шийдвэрлэх явцад шинжээчийг заавал бус, шаардлагатай нөхцөлд оролцуулах боломжийг нээж, мөн тухайн хүүхдийн нас, хөгжлийн онцлогийг харгалзан гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажилтан, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч болон бусад

холбогдох этгээдийг оролцуулах эсэхийг шүүх өөрөө шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан нь чухал ахиц гэж үзэхээр байна.

Үүнээс гадна гэрлэгчдэд чиглэсэн зөвлөгөө, мэдээллийн хангалттай бус байдал, гэр бүлийг дэмжих бодлого сул хөгжсөн, ялангуяа сэтгэл зүйн үйлчилгээний хүртээмж бага, төлбөр өндөр, мөн гэр бүл цуцлалтаас урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээ хангалтгүй байгаа нь гэр бүл салалтын түвшин нэмэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нэг болж байна.

Иймд энэхүү тулгамдсан асуудлын гол цөм нь гэр бүл цуцлах бодит шалтгаан хууль тогтоомжид тодорхой заагдаагүйгээс үүдэн, шүүхийн тайлбар, практик болон нийгмийн бодит харилцаа гэр бүл цуцлах үндэслэлийг тодорхойлж ирсэн явдалд оршиж байна. Энэ нь Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн зохицуулалтад материаллаг үндэслэлийг тодорхой болгох шинэчлэл зайлшгүй шаардлагатай байсныг харуулж байна.

Зураг 2.6 Гэрлэлт цуцлах болсон шалтгаан (2024-2025 оны байдлаар)



Эх сурвалж: Шүүхийн шийдвэрийн цахим сан

2025 оны байдлаар шүүхийн шийдвэрийн цахим сангаас гэрлэлт цуцлалттай холбоотой маргааныг шийдвэрлэсэн 50 гаруй шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд гэрлэлт цуцлах болсон гол шалтгаануудад хосуудын таарамжгүй харилцаа (40%), тус, тусдаа амьдарч байгаа (24%), архидалт (14%), гэр бүлээс гадуурх харилцаа (12%), гэр бүлийн хүчирхийлэл (10%) зэрэг шалтгаанууд тэргүүлж байна.

Хүснэгт 2.7 Шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэсэн гэрлэлт цуцдуулсан хэргийн дүн шинжилгээ

№	Шүүх	Шийдвэрийн огноо, дугаар	Шийдвэрийн агуулга, үндэслэл
---	------	--------------------------	------------------------------

1	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	2025-09-23 313/ШШ2025/00459	Нэхэмжлэгч буюу эхнэр нь гэр бүлээ цуцлуулах нэхэмжлэлийн үндэслэлдээ “нөхрийн буюу хариуцагчийн зан ааш өөрчлөгдөж, гэрт байнгын хэрүүл маргаантай байдаг бөгөөд үзэл бодол нийлэхээ больсон” гэж дурджээ. Харин хариуцагчийн гаргасан хариу тайлбарт зааснаар “гэр бүлдээ тавих анхаарал халамж алдагдсан, хоёр биеэ гэх сэтгэл хөрсөн” гэж тайлбарлажээ. Хоорондын ямар нэгэн эд хөрөнгийн болон хүүхдийн тэтгэлгийн талаарх маргаангүй тул шүүх гэрлэлтийг цуцалсан байна.
2	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2025-10-08 191/ШШ2025/08516	Нэхэмжлэгч гэр бүлээ цуцлуулах үндэслэлээ нэхэмжлэлдээ тусгахдаа “араар тавилт, сэтгэл зүйн шарх, бие махбодын шарх зэргээс үүдэн цаашид амьдрах боломжгүй болсон тул гэр бүлийг цуцалж өгнө үү” гэжээ. Хариуцагч өөрийн ирүүлсэн хариу тайлбартаа “Бид хоёр амьдраад 15 жил болсон. Уг хугацаанд араар тавилт архидалтаас болоод салах шийдвэрт хүрч байна. Гэрлэлт цуцлуулахыг хүлээн зөвшөөрч байна.” гэсэн байна. Нэхэмжлэгч нь “хариуцагч А. нь гэр бүлээс гадуур харилцаа үүсгэж, сэтгэл санааны шарх, бие махбодын шархнаас үүдэн цаашид хамтран амьдрах боломжгүй болсон тул гэрлэлт цуцлуулах шийдвэр гаргасан” гэж тайлбарласныг хариуцагч үгүйсгэж маргаагүй, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь зөвшөөрсөн. Зохигчид хэн аль нь зан харилцааны таарамжгүй байдлын улмаас тусдаа амьдарч байгаа, харилцаа хөндийрсөн гэж тайлбарласан. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авчны дараа эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулалгүйгээр гэрлэлтийг цуцалжээ.
3	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2025-10-08 191/ШШ2025/08517	Нэхэмжлэгч гэр бүлээ цуцлуулах үндэслэлээ нэхэмжлэлдээ тусгахдаа “Бидний гэрлэлтээ цуцлуулах болсон шалтгаан нь хариуцагч нь гэр бүлээс гадуурх амьдрал зохиосон. Би тэр асуудлыг нь мэдэхгүй их удаан явсан. Учир нь тэрээр цагдаагийн байгууллагад алба хашдаг байсан тул

			байнга л ажилтай, жижүүртэй гэх шалтгаанаар гэртээ хонохгүй байсан үе маш олон байдаг байсан. Тэрээр тэр хүүхэнтэйгээ хамт амьдраад хүүхэдтэй хүртэл болсон.” гэжээ. Хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч, маргаагүй мөн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон тул шүүх гэрлэлтийг цуцалсан байна.
4	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	2025-10-03 313/ШШ2025/00496	Нэхэмжлэгч шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ дурдахдаа “Хариуцагчтай таарч тохирохгүйн улмаас салсан. Түүнээс хойш 15 жил болсон ба одоо гэрлэлтээ цуцлуулах хүсэлтэй байна. Хүүхдийн сургууль хөөцөлдөх гэхээр гэрлэлтийн баталгаа болохгүй, бичиг баримтын зөрчил гараад болохгүй байгаа учраас гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргасан. Одоогийн эхнэртэйгээ гэрлэлтээ бүртгүүлмээр байгаа.” гэжээ. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, гэрлэгчдийн аль аль нь гэрлэлт цуцлуулах хүсэлтэй байгаа, гэрлэгчдийн таарамжгүй харилцаа нь хүүхдийн хүмүүжилд муугаар нөлөөлж болзошгүй байгаа байдал зэргийг харгалзан гэрлэгчдийн дунд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дахин явуулах шаардлагагүй хэмээн гэрлэлтийг цуцалж шийдвэрлэсэн байна.
5	Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	2019-12-25 142/ШШ2020/00019	Нэхэмжлэгч шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ гэрлэлт цуцлуулах шалтгаанаа дурдахдаа “Хоорондын зан харьцааны хувьд таарч тохирохгүй нөхрийн архи уудгаас болж тусдаа амьдарснаар салах болсон” гэсэн байна. Нотлох баримтаар талуудын өөрсдийн гаргасан гэрлэлтийн гэрчилгээ, зохигчийн тайлбар, хүүхдийн гэрчилгээний хуулбар зэрэг нотлох баримтуудаар тогтоогдсон шүүхээс нотлох баримт цуглуулаагүй. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан боловч гэрлэгчид эвлэрээгүй байна.

Эх сурвалж: Шүүхийн шийдвэрийн цахим сан

Дүгнээд үзэхэд, эдгээр 5 шийдвэрүүдээс тусдаа амьдралтай болсон 3,

архидалтаас болсон 2, мөн хоорондын таарамжгүй байдал, өөр хүнтэй хамтран амьдрах шалтгаан зэргээс болж гэрлэлт цуцалсан байна.

Иймээс гэр бүл цуцлахтай холбоотой шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулах, гэр бүлийн холбогдолтой хэргийг шийдвэрлэх шүүгчдийн мэргэшлийг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах тусгай аргачлал нэвтрүүлэх шаардлагатай байна.

2.4 Гадаад орнуудын гэр бүл цуцлалтын эрх зүйн зохицуулалтын онцлог

Сонгон авсан гадаад улс орнуудын харьцуулсан судалгааг хийхдээ Монгол улстай эх газрын эрх зүйн бүлд нэгэн адил хамаардаг (ОХУ, Япон болон БНСУ) улс орнуудын тогтолцоог судалсан бөгөөд нийтлэг эрх зүйн бүлд хамаарах нэгэн улстай (Их Британи) харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ. Иймд эдгээр улсуудын хуулийн зохицуулалтыг Монгол Улсын Гэр бүлийн тухай хуультай харьцуулах замаар гэр бүл цуцлах үндэслэлийг хуульчлах, эсхүл процессоор орлуулах боломж, мөн шүүхийн практикт үүсч буй зөрчлийг тодорхой нэгэн хэмжээгээр бууруулах чиглэлийг тодорхойлох зорилго тавьсан болно.

Оросын холбооны улс /ОХУ/

ОХУ-н Гэр бүлийн тухай хууль (Семейный кодекс РФ) нь Орос улсын гэр бүлийн харилцааг зохицуулдаг гол эх сурвалж бөгөөд 1995 оны 12-р сарын 29-ний өдөр Төрийн Думаас № 223-ФЗ дугаартайгаар батлагдаж, 1996 оны 3-р сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Тус хуульд 1997 оны 11-р сарын 15 болон 1998 оны 6-р сарын 27-нд тус тус нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд эцэг, эх, хүүхдийн болон гэр бүлийн бусад гишүүдийн эрх, ашиг, сонирхлыг төрийн зүгээс хамгаалах, гэр бүлийн эрх зүйн харилцааг гэр бүлийн гишүүд хоорондын харилцан хүндэтгэл, хайр, тэгш эрхийн зарчимд үндэслэн зохицуулахыг гол зорилго болгосон байдаг.

XVI зууны үеийн Орос улсад хүн төрсөн, нас барсан, гэр бүл бололцсон болон гэр бүлээ цуцлуулсан зэрэг иргэний бүртгэлийг зөвхөн Ортодокс сүм хийд хариуцдаг байжээ. Эдгээр үндэслэлээс дурдвал, эхнэр нь нөхрөөсөө өөр гадны хүнтэй хамт хооллох, нэг оронд унтах зэрэг үйлдэл гаргасан тохиолдолд үүнийг “садар самуун”, “хууран мэхлэлт” гэж үздэг байсан тул нөхөр нь тухайн үндэслэлээр эхнэрээсээ салах бүрэн эрхтэй байсан байна. Гэвч энэхүү заалт нь нөхрийн талд адил үйлчилдэггүй буюу эрэгтэй хүн хүссэн хүнтэйгээ хооллож, ууж, нэг оронд хонож болох бөгөөд үүний төлөө сүмд торгууль төлөх л үүрэг хүлээж, эхнэр нь энэ тухай гомдол ч гаргах эрхгүй байсан

нь хүйсээр ялгаварлан гадуурхсан үзэл хүчтэй явагддаг байсны илрэл юм. Энэ нь гэр бүлийн харилцаа төдийгүй хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны зарчмыг хууль ёсны хүрээнд хангалттай хэмжээнд хангадаггүй байсан гэдгийг нотолж болно. Тиймээс эдгээр олон шат дамжлага, шударга бус зохицуулалт, нотолгоо зэргээс төвөгшөөсний улмаас гэрлэгчид гэр бүлээ цуцлуулахын оронд зүгээр л тусдаа амьдрах арга замыг илүүд үзэж сонгодог байжээ. (LEVIN, E. 1989. Marriage. In Sex and Society in the World of the Orthodox Slavs 900–1700 (pp. 79–135). Cornell University Press. <http://www.jstor.org/stable/10.7591/j.ctv5rdxvf.8>)

Орчин үеийн Гэр бүлийн тухай хуулинд нь зааснаар гэр бүл цуцлах журмыг тус хуулийн “4 дүгээр бүлэг: Гэрлэлт цуцлах” бүлгийн 16-25 дугаар зүйлд тусгаж өгчээ.

ОХУ-д гэрлэлтийг хуульд зааснаар дараах үндэслэлээр цуцалдаг:

- Эхнэр, нөхрийн аль нэгнийх нь санаачилгаар;
- Гэрлэгчдийн хоёр талын зөвшөөрлөөр;
- Хэн нэг нь нас барсан, эсвэл сураггүй болсон тохиолдолд гэрлэлт шүүхийн журмаар дуусгавар болно.

Тус хуулийн 16-р зүйлийн 2 дахь хэсэгт “Гэрлэлтийг эхнэр, нөхөр хоёрын аль нэгнийх нь хүсэлтээр, түүнчлэн эрх зүйн чадамжгүй гэж шүүхээс хүлээн зөвшөөрсөн эхнэр, нөхөр, асран хамгаалагчийн хүсэлтээр цуцалж болно.” гэж заасан байдаг.

Гэр бүл цуцлах журмын хувьд:

- Эд хөрөнгийн маргаангүй, 18 хүртэлх насны хүүхэдгүй, харилцан зөвшилцсөн бол Иргэний бүртгэлийн газарт өргөдлөө өгөөд, гэрлэлтээ цуцлуулж болно.
- Хэн нэг нь гэрлэлтээ цуцлуулахаас татгалзсан эсхүл насанд хүрээгүй хүүхэдтэй бол шүүхийн журмаар цуцална.

Хүснэгт 2.8 Монгол улс болон ОХУ-н гэрлэлт цуцлах эрх зүйн зохицуулалтын ялгаа

Үзүүлэлт	Монгол Улс	ОХУ /Орос/
Гэрлэлт цуцлах байгууллага	Иргэний хэргийн шүүх, иргэний улсын бүртгэлийн газар	Иргэний шүүх, ОХУ-ын ЗАГС (ЗАГС — “Запись актов гражданского состояния”) буюу Иргэний бүртгэлийн газар
Эвлэрүүлэх хугацаа	“Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 20.1-д зааснаар 30 хоног	1-3 сар

Насанд хүрээгүй хүүхэдтэй тохиолдолд	Зөвхөн шүүхээр гэрлэлтийг цуцална.	Зөвхөн шүүхээр гэрлэлтийг цуцална.
Эд хөрөнгийн эрхийн хуваарилалт	Гэрлэгчдийн эд хөрөнгийн эрхийн гэрээ эсвэл шүүхийн шийдвэр	Тэнцүү зарчмаар
Гэр бүлийн хүчирхийлэл	“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” 2016 он	Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Гэр бүлийн тухай хууль

Эх сурвалж: "Семейный кодекс Российской Федерации" 29 декабря 1995 года N 223-ФЗ

ОХУ-ын гэр бүлийн эрх зүйн харилцааны систем нь талуудын тэгш эрх, бие биенээ харилцан хүндэтгэх, хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалах, гэр бүлийн бие даасан байдал гэсэн эдгээр суурь үнэт зүйл дээр тулгуурладаг. Хуулийн зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Гэр бүлийн тухай хуультай төстэй, гэхдээ төр нь гэр бүлийг хамгаалах үүрэгтэй боловч гэр бүлийн дотоод асуудалд хэт оролцох ёсгүй гэж хуульчилснаараа онцлогтой.

Хүснэгт 2.9 Орос улсын гэр бүл цуцлуулах журам

№	Иргэний бүртгэлийн газар (ЗАГС)-аар гэр бүл цуцлуулах нөхцөл	Шүүхээр гэр бүлээ цуцлуулах нөхцөл
1	Хоёр тал гэр бүл цуцлах талаар хоорондоо тохиролцсон	Хоёр тал хоорондоо тохиролцоогүй.
2	Нэг тал нь сэтгэцийн өвчтэй, эрх зүйн чадамжгүйд тооцогдсон	Дундаа үр хүүхэдтэй.
3	Нэг тал нь хорих ял эдэлж байгаа (3 жилээс дээш хугацаагаар)	Гэр бүлийн эрх зүйн харилцаа дуусгавар болсон, үргэлжлүүлэн хамт амьдрах боломжгүй.
4	Нэг тал нь сураггүй алга болсон гэж шүүхээр тогтоогдсон	Гэр бүлийн хүчирхийлэл, архидалт, бие биенээ гэх сэтгэл хөрсөн.


Эх сурвалж: Семейный кодекс РФ, 19-23 дугаар зүйл

Шүүхийн практикт гардаг ихэнх гэр бүл цуцлуулах болсон шалтгаануудыг дурдвал:

- Хоорондын таарамжгүй харилцаа
- Үнэнч бус байдал
- Гэр бүлийн хүчирхийлэл
- Архидалт, мансууруулах бодисын хэрэглээ
- Ажилгүйдэл, гэр бүлийн санхүүгийн хүндрэл
- Гадаадад ажиллах, гэр бүлээсээ хол амьдрах
- Хүүхдээ хүмүүжүүлэх арга барилын ялгаа (<https://divorceinrussia.com/russian-divorce->

[statistics/#:~:text=infidelity%20%5B24%25%5D,15%25%20of%20divorces%20to%20it\)](#)

Зураг 2.7 ОХУ-ын гэр бүл цуцлалтын тоон үзүүлэлтүүд (2021-2024 оны байдлаар)



Эх сурвалж: "Russia Has a Divorce Problem" https://www.newsweek.com/russia-has-divorce-problem-2004356?utm_source

Орос улс нь гэр бүл салалтын түвшингээрээ дэлхийд дээгүүрт тооцогддог улс бөгөөд 2024 оны байдлаар тус үзүүлэлт бага зэрэг буурсан ч 1960-аад оноос хойш өндөр хэвээр байна гэж Оросын Анагаах ухааны үндэсний номын сангаас гаргасан "Оросын гэр бүл салалтын урт хугацааны таамаглал" номд дурдагдсан байна. Ийнхүү гэр бүл цуцлалт өндөр түвшинд хүрсэн байдал нь гэрлэлт тогтвортой үргэлжлэхгүй байх, албан ёсны гэрлэлтээс зайлсхийх, гэрлэлтээ бүртгүүлэхгүйгээр хамтран амьдрах хэлбэр нэмэгдэхэд нөлөөлсөн бөгөөд үүний улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол, эрх зүйн хамгаалалт, тэтгэмжийн хэрэгжилтэд хүндрэл гардаг.

ОХУ нь Ром - Германы буюу эх газрын эрх зүйн уламжлалт тогтолцоонд тулгуурлан гэрлэлт бодитоор оршин тогтнох боломжгүй болсон эсэхийг үндсэн шалгуур болгон гэрлэлтийг цуцалдаг, шүүх нь гэр бүлийн харилцааны дуусгавар болох үндсэн шалтгаан, сэтгэл зүйн онцлогийг шийдвэрлэхэд зориулагдсан байгууллага биш гэж үздэг тул гэр бүлийн маргааныг зөвхөн хууль зүйн хүрээнд таслан зогсоохоос цааш гүнзгийрүүлсэн ахиц дэвшилтэй шийдэл өгч чаддаггүй. Эвлэрүүлэн зуучлалын тогтолцооны үйл явц нь ихэвчлэн хуульд заасан формаль үе шат хэлбэрээр хэрэгжиж, гэрлэгчдэд зориулсан оновчтой сэтгэл зүйн зөвлөгөө, гэр бүлийн зөвлөх үйлчилгээтэй уялддаггүй. Үүний улмаас эвлэрүүлэн зуучлах ажиллагаа бодит үр дүнд хангалттай хэрэгжих бус, гэрлэгчид тус шатанд эвлэрэхээс илүүтэй “шүүхийн хугацаа хожих” хэрэгсэл болон хувирч, эцэстээ гэрлэлт цуцлах шийдвэрт нөлөөлдөггүй байна.

Явцын дүгнэлт

ОХУ болон Монгол Улсын гэр бүл цуцлалтын эрх зүйн зохицуулалт нь хэлбэрийн хувьд ялгаатай мэт боловч бодит практикт ижил төстэй тулгамдсан асуудлууд ажиглагдаж байна. Тухайлбал, гэрлэлт цуцлах нөхцөлд шүүхийн оролцоо зайлшгүй болж, гэрлэгчдийг эвлэрүүлэн зуучлах механизм үр дүн багатай, хүүхдийн эрх ашиг хангалттай хэмжээнд хамгаалагдахгүй хэвээр байна. Иймд Монгол Улс болон ОХУ-ын гэр бүлийн холбогдолтой маргаанд гэм буруутай этгээдийг олох гэхээс илүүтэйгээр гэрлэлтийн бодит оршин тогтнолыг шалгуур болгодог хандлагыг нэвтрүүлэхийн зэрэгцээ эвлэрүүлэн зуучлах тогтолцоо, гэрлэгчдийн сэтгэл зүйг тогтвортой байлгах чанарыг бодитой сайжруулах шаардлагатай байна.

Япон

Япон Улсад гэр бүлийн эрх зүйн харилцааг “Иргэний хууль” (Civil Code of Japan, Minpō) болон “Гэр бүлийн шүүхийн тухай хууль” (Family Court Act)-аар тус тус зохицуулдаг.

Тус Иргэний хууль нь анх 1896 онд батлагдан 1898 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Гэхдээ гэр бүлийн эрх зүйн харилцаатай холбоотой 4 дэх бүлэг (Book IV: Family) болон өв залгамжлалтай холбоотой 5 дахь бүлэг (Book V: Inheritance) зэрэг хэсгүүд нь 1947 онд шинэчлэгдэн батлагдсан бөгөөд тус шинэчлэл нь Дэлхийн II дайны дараах 1947 оны Японы Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлж, дараах үндсэн ардчилсан зарчмуудыг тусгаснаараа онцлогтой.

- Хувь хүний эрх, эрх чөлөө, хүйсийн тэгш байдал
- Гэр бүлийг хоёр талын харилцан зөвшилцөлд тулгуурлан байгуулах зарчим
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх
- Эцэг эх, хүүхдийн эрхийг төрөөс хамгаалах зэрэг орно.

Япон улсад гэр бүл цуцлалтыг 4 хэлбэрээр шийдвэрлэдэг:

Хүснэгт 2.10 Япон улсын гэрлэлт цуцлалтын хэлбэр

№	Хэлбэр	Тайлбар	Хуулийн зохицуулалт
1	Харилцан тохиролцсон цуцлалт	Хоёр тал гэрлэлтээ цуцлуулахаар харилцан зөвшилцөж, иргэний бүртгэлийн газарт бүртгүүлдэг.	Иргэний хууль 763-р зүйл
2	Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа	Гэр бүлийн шүүхэд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах	Family Court Act

		журмаар шийдвэрлэнэ.	
3	Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа амжилтгүй болсон тохиолдол	Эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болвол иргэний шүүх шийдвэр гаргаж, гэрлэлтийг дуусгавар болгоно.	Иргэний хууль 770-р зүйл
4	Шүүхээр гэрлэлтээ цуцлуулах	Гэр бүлийн хүчирхийлэл эсхүл нэг талын хүсэлтээр, нотолгооны үндсэн дээр шүүх шийдвэр гаргаж гэрлэлтийг цуцална.	Иргэний хууль 770-р зүйлийн 1 дүгээр хэсэг

Эх сурвалж: “The Civil Code of Japan”

Япон улсын Иргэний хуулийн 770-р зүйлд хэрвээ харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрлэлтээ цуцлуулж чадахгүй бол дараах 5 үндэслэлээр гэр бүл цуцалж болно гэж заасан байна. Эдгээр нь:

- Нөхөр эсхүл эхнэр нь гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэн, завхайрсан (adultery);
- Нэг тал нь орон гэрээ орхин удаан хугацаанд холбоо тасарсан;
- 3 жил буюу түүнээс дээш хугацаанд оршин байгаа эсэх нь тодорхойгүй;
- Нэг тал нь “сэтгэцийн өвчтэй” бөгөөд эдгэрэх найдваргүй болсон буюу эрх зүйн чадамжгүй болох;
- Бусад ноцтой шалтгаанаар гэрлэлтийг үргэлжлүүлэх боломжгүй болсон.


Энэ “бусад ноцтой шалтгаан” гэсэн хэсэг дотор гэр бүлийн хүчирхийлэл, архины хамаарал, гэр бүлийн санхүүгийн байдалд үл оролцох, бие биендээ итгэл алдрах зэрэг шалтгаан ордог.

Тус улсын гэр бүл цуцлалтын онцлог нь гэр бүл цуцлах ихэнх тохиолдол буюу 80-90% нь харилцан тохиролцсон хэлбэрээр хийгддэг. Энэ нь хосууд гэрлэлтээ дуусгавар болгохдоо зөрчил, маргаанаас илүүтэйгээр харилцан зөвшилцөл, бодит байдлыг хүлээн зөвшөөрөх хандлагатай байгааг харуулж байгаа бөгөөд Япон улсын нийгэмд гэр бүл цуцлалтыг зайлшгүй “буруутныг тогтоох” асуудал гэж биш харин амьдралын бодит нөхцөлтэй уялдуулан шийдвэрлэх ойлголт давамгайлж байгаатай холбоотой. Гэр бүлийн шүүх болох “Katei Saibansho” нь гэр бүлийн маргаан гарсан тохиолдолд хууль зүйн бус сэтгэл зүйн дэмжлэг, эвлэрүүлэн зуучлалын үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдийн тэтгэмж, тэтгэлэг, эд хөрөнгийн эрхийн хуваарилалтын асуудлыг тус шүүх тусдаа шийдвэрлэдэг.

Япон улсын эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний яамны хүн ам зүйн

статистик мэдээгээр 2022 оны байдлаар нийтдээ 179,099 хос гэрлэлтээ цуцлуулсан бөгөөд сүүлийн үед тус улсын хүн амын тоо буурч, гэрлэлтийн тоо буурах хандлагатай байгаа тул гэр бүл цуцлалтын тоо ч мөн адил буурч байна гэж үзэж болно. (https://www.mk.co.kr/en/world/11091854?utm_source)

Зураг 2.8 Япон улсын гэрлэлт болон гэр бүл цуцлалтын түвшин, 1000 хүнд ногдох байдлаар (1970-2008 он)



Эх сурвалж: Японы хүн амын статистик 2010, Хүн ам, нийгмийн хамгааллын судалгааны үндэсний хүрээлэн

Орчин үеийн чиг хандлагын хүрээнд 2024 оны байдлаар Япон улсад гэр бүл цуцлалт 1.7%-тай буюу 1,000 хүн тутамд 1.7 болж буурсан үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч гэр бүлийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, эдийн засгийн бие даасан байдал зэрэг хүчин зүйл нөлөөлсөн байжээ. (National Police Agency of Japan, 2025 оны 2-р сарын мэдээ).

Япон Улсын гэр бүл цуцлалтаас сэргийлэх бодлого, арга хэмжээний хувьд “Children and Families Agency” нь 2023 оны 4 дүгээр сард шинээр байгуулагдсан төрийн байгууллага бөгөөд тус улсын төр, засгаас төрөлт бууралт, гэр бүлийн тогтворгүй байдал, гэр бүл цуцлалтын дараа хүүхдийн хамгааллыг сайжруулах зорилгоор үндэсний түвшний бодлогын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Тус байгууллагын гэр бүл, хүүхдэд чиглэсэн бодлого, дэмжлэгийн хүрээнд дараах үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байна.

Хүснэгт 2.11 Япон улсын гэрлэлт цуцлалтыг бууруулахад хэрэгжүүлдэг бодлого

Хэрэгжүүлдэг бодлого, дэмжлэг		Зорилго
Хүүхэд дэмжих бодлого	төрүүлэхийг санхүүгийн	Япон улсад гэр бүл цуцлалтын томоохон шалтгаанд санхүүгийн дарамт, хүүхэд өсгөх зардал багтдаг байна. Тус агентлаг нь дараах бодлогуудаар гэр бүлийн санхүүгийн дарамтыг ямар нэгэн хэмжээгээр бууруулдаг:

	• 児童手当 (Child Allowance) – Хүүхэдтэй айл өрхүүдэд сар бүр олгодог тэтгэмж. (¥30,000/сар бүр) • 出産育児一時金 (Childbirth Lump-sum Payment) – Төрөх үед олгох нэг удаагийн тэтгэмж. (¥500,000/төрөх бүрт) • 妊婦検診の助成 (Prenatal check-up subsidies) – Жирэмсний үзлэг, шинжилгээний зардлын дэмжлэг. (¥50k төрөлтөнд, ¥50k төрсний дараа) • 保育料減免制度 (Nursery / daycare fee reduction) – Хүүхдийн цэцэрлэг, яслийн төлбөрийг бууруулах, үнэ төлбөргүй болгох. Эдгээр бодлогууд нь хосууд хүүхэдтэй болох, өсгөхөд гарах санхүүгийн дарамтыг бууруулж гэр бүл цуцлалт, санхүүгийн стрессийг бууруулах зорилготой.
Эцэг эхэд зориулсан зөвлөгөө, сэтгэл зүйн дэмжлэг	Тус агентлагийн нэг гол чиглэл нь гэр бүлийн харилцаанд үүсч болох асуудлыг даамжрахаас нь өмнө эрт илрүүлэх, түүнд тохирсон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүл цуцлалтаас сэргийлэх юм. • 家庭相談センター (Family Consultation Centers)– Гэр бүлийн маргаан, хүүхдийн хүмүүжлийн арга барил, хосуудын харилцаатай холбоотой зөвлөгөө. • 産後ケア (Postpartum care programs) – Төрсний дараах ээжүүдэд өгөх сэтгэл зүйн дэмжлэг. • 夫婦カウンセリング (Marriage counseling)– Хосуудын харилцааны үл ойлголцол, зөрчлийг багасгах.
Ажил–амьдралын тэнцвэрийг дэмжих бодлого (Work-life balance support)	Япон улсад ажил ихтэй, илүү цагаар ажиллах нь гэр бүлийн болон хосуудын харилцаанд сөргөөр нөлөөлдөг гэж судалгаанд тэмдэглэгдсэн байдаг байна. CFA нь дараах бодлогоор дэмжлэг үзүүлдэг: • 育児休業 (Childcare leave) – Ээж, аав аль аль нь

	авах боломжтой. • パパ育休 (Paternity leave promotion programs) – Аавуудын хүүхдээ асрах оролцоог нэмэгдүүлэх, цалинтай чөлөө олгох. • フレックスタイム制度 (Flexible work schedules) – Уян хатан ажлын цаг.
Өрх толгойлсон эцэг, эхэд зориулсан дэмжлэг (Single-parent support)	• 児童扶養手当 (Child-rearing allowance) – Cap бүрийн мөнгөн тусламж. (¥15k/0-3 нас, ¥10k/3-15 нас, ¥10k/15 нас) • 就労支援 (Employment support) – Ажил олоход зуучлах. • 生活保護 (Welfare programs) – Орлого багатай өрхийн амьжиргаанд туслах.
Хүүхдийн аюулгүй байдал, хамгааллын бодлого (Child protection)	CFA-ийн бас нэг гол томоохон зорилт бол хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах явдал юм. Үүний хүрээнд: • 児童虐待防止法 (Child Abuse Prevention Law) • Хүүхдийн нийгмийн халамжийн төвүүд, түр хамгаалах байр.

Эх сурвалж: https://www.cfa.go.jp/policies/?utm_source Children and families agency

Хүүхэд, гэр бүлийн агентлагийн явуулж буй эдгээр бодлого нь шууд гэр бүл цуцлалтыг зогсоох гэхээс илүүтэй гэр бүлийн харилцаанд гарч буй стресс, дарамтыг багасгаж, хүүхэд өсгөх орчныг сайжруулснаар гэр бүл цуцлалтын эрсдэлийг бууруулах зорилготой.

Явцын дүгнэлт

Япон улсын Иргэний хуулийн 770 дугаар зүйлд гэр бүл цуцлах үндэслэлийг тодорхой, материаллаг байдлаар хуульчилсан нь шүүхийн практикийг нэг мөр болгох, эрх зүйн тодорхой байдлыг хангах давуу талтай. Харин Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль дахь одоогийн зохицуулалтад гэр бүл цуцлах бодит үндэслэлийг хуульд тодорхой тусгаагүйгээс шалтгаалан нийгэмд гарч буй бодит шалтгаанууд шүүхийн үзэмжээр явагдаж ирсэн нь практик зөрчил, тодорхой бус байдлыг бий болгосон гэж дүгнэж байна.

Мөн тус улсын гэр бүл цуцлалтын ихэнх хувийг гэрлэгчид харилцан

тохиролцсон хэлбэрээр хийдэг нь Япон улсад салалтыг харилцан ойлголцлын үр дүн гэж үзэх хандлага давамгайлдаг бол Монгол улсад салалт нь ихэвчлэн гэрлэгчдийн хоорондын маргаан, сэтгэл зүйн зөрчил, эрх тэгш бус харилцааны үр дагавар болж байна. Иймд Япон Улсын туршлагаас харахад гэр бүл цуцлалтыг заавал маргаантай, нэг талын буруутгалд суурилсан үйл явц байхаас илүүтэйгээр хосуудын амьдралын бодит нөхцөл, цаашдын харилцааны үргэлжлэх боломжид тулгуурлан харилцан зөвшилцөх байдлаар шийдвэрлэх нь сөрөг үр дагаврыг бууруулах ач холбогдолтой байна. Харин Монгол Улсад гэр бүл цуцлалтын шийдвэр ихэвчлэн нэг талын санаачилгаар, маргаантай хэлбэрээр хийгдэж байгаа нь гэр бүлийн харилцаанд урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх, эвлэрүүлэн зуучлах тогтолцоог боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

Их Британи

Их Британи нь гэр бүл цуцлалт (divorce), хууль ёсны тусдаа амьдрал (legal separation), мөн иргэний түншлэлийн (civil partnership dissolution) асуудлаар дэлхийд хамгийн цэгцтэй, шүүхийн практикт тулгуурласан системтэй улс орон юм.

Тус улсын Гэр бүлийн эрх зүй нь хувь хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны зарчим, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үзэл баримтлалд тулгуурладаг бөгөөд орчин үеийн “no-fault divorce” буюу тодорхой нэгэн этгээдийг буруутгахгүйгээр хууль ёсны гэр бүл цуцлалтын тогтолцоог нэвтрүүлснээрээ онцлогтой.

Хүснэгт 2.12 *Их Британий шүүхийн тогтолцоо*

Их Британий улсууд	Хамаарагдах шүүхийн тогтолцоо
Англи, Уэльс	Family Court
Шотланд	Sheriff Court
Хойд Ирланд	Family Proceedings Court

Эдгээр шүүхүүд нь гэр бүл цуцлалт, хүүхдийн асрамж, эд хөрөнгийн эрхийн маргаан зэрэг бүх төрлийн гэр бүлийн хэргийг хариуцаж шийдвэрлэдэг.

Гэр бүлийн харилцаатай холбоотой эрх зүйн нийтлэг зохицуулалт нь Их Британийн 1996 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуульд (Family Law Act, 1996) тусгагдсан байдаг. Тус хууль тогтоомж нь 5 бүлэг, 67 зүйлээс бүрдэн, гэрлэлт цуцлах үйл явц, түүнээс өмнөх туршилтын хугацаа, гэр бүл цуцлалтын эрсдэлийг бууруулах бодлого, эвлэрүүлэн зуучлах тогтолцооны зохион байгуулалт зэрэг өргөн хүрээний асуудлыг хамардаг.

2019 онд бүртгэгдсэн гэр бүл цуцлалтын 108,421 тохиолдлоос гэрлэгчдийн гэр бүлээ цуцлуулж буй шалтгаан дотроос хамгийн түгээмэл нь “зан төлөв, харилцааны өөрчлөлт” болж нийт гэр бүл цуцлалтын ойролцоогоор 46.5%-ийг эзэлсэн байна. Дараагийн ноцтой шалтгаан нь хосууд 2 жил туурга тусгаар буюу тус, тусдаа амьдарсан явдал (26.7%), түүнээс цааш 5 жилийн турш тус, тусдаа амьдарсан гэр бүлүүд (15.4%) байжээ. Харин гэр бүлээс гадуурх харилцаа нь гэр бүл цуцлалтын шалтгаан болох тохиолдлуудын 10.5%-ийг бүрдүүлжээ. (Гэр бүл салалт, гэр бүлийн харилцааны зөрчил шийдвэрлэлтийн талаарх бусад орнуудын туршлага ба Монгол улсын нөхцөл байдал, харьцуулсан судалгаа)

Хүснэгт 2.13 *Их Британи улсын гэр бүл цуцлалтын шалтгаан (2018-2020 он)*

Хамрагдах цаг үе	Гэр бүл цуцлалтын шалтгаан	Эх сурвалж
2018 он	Тус онд гэрлэлтээ цуцлуулсан хүмүүсийн дунд хамгийн их хувийг эзэлсэн шалтгаан нь “ямар ч шалтгаангүй сонин аашлах буюу хоорондын таарамжгүй байдал (unreasonable behaviour)” оржээ.	https://cy.ons.gov.uk/ “Unreasonable behaviour was the most commonly used ground for divorce by both opposite-sex and same-sex couples”
2019 он	Тус онд ижил хүйстэн болон эсрэг хүйстэн хосуудын хувьд “хоорондын таарамжгүй байдал” хамгийн түгээмэл үндэслэл байсан.	https://www.ons.gov.uk/ “Grounds for divorce”
2020 он	Тухайн онд гэр бүл цуцлах гол шалтгаан нь мөн адил “хоорондын таарамжгүй байдал” (unreasonable behaviour) байв. Мөн гэр бүл цуцлах хамгийн түгээмэл дараагийн үндэслэл нь “хоёр жилийн турш тусдаа амьдарсан байдал” (two years’ separation) байжээ.	“Divorces in England and Wales: 2020” “Main points”

Эх сурвалж: <https://www.ons.gov.uk/>

Тус улсад 2022 оны 4 сарын 6-ны өдөр “Divorce, Dissolution and Separation Act 2020” буюу “Гэр бүл цуцлах тухай хууль” нь батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд гол зорилго нь гэр бүл цуцлалтын үйл явцыг хөнгөвчлөх, талуудын хоорондын эд хөрөнгийн болон амины эрхийн маргааныг эв зүйгээр шийдвэрлэх, хамгийн гол нь хүүхдийн эрх ашиг, гэрлэгчдийн ирээдүйн амьдралд гол анхаарлаа хандуулж, гэр бүл цуцлалтад хэн нэгнээ буруутгахгүйгээр, шүүхийн чухал практик шийдвэрт гол анхаарлаа төвлөрүүлдэг байна.

Энэхүү зохицуулалт нь гэр бүлийн шударга ёсны зарчмыг бэхжүүлэхэд чиглэсэн

бөгөөд гэр бүл цуцлах явцад хосууд бие биеэ буруутгах, өс хонзон тээх, улмаар хүүхдэд сөрөг үлгэр дууриалал үзүүлэх, сэтгэл зүйн хор уршиг учруулахаас сэргийлэх ач холбогдолтой. Хуульд заасан “reflection period” буюу 20 долоо хоногийн эргэцүүлэх хугацаа нь хосуудад шийдвэрээ дахин тунгаан бодох, эвлэрэх боломжийг эрэлхийлэх, мөн хүүхдийн эрх, эд хөрөнгийн асуудлыг нухацтай зохицуулах цаг хугацааг олгодог. Гэр бүл цуцлуулах өргөдөл гаргаснаас хойш 20 долоо хоног өнгөрсний дараа, нэмэлт 6 долоо хоногийн дараа шүүх “Conditional Order” гаргаж, нийт 26 долоо хоногийн дараа гэр бүл цуцлалтын эцсийн шийдвэр хүчин төгөлдөр болдог. Энэ хугацаанд эвлэрүүлэн зуучлал, сэтгэл зүйн дэмжлэг, хосын зөвлөгөө зэрэг үйл ажиллагааг зохицуулах боломж бүрддэг. Их Британий 2023–2024 оны шүүхийн статистик мэдээллээс харахад уг зохицуулалт нэвтэрснээр гэр бүл цуцлуулах хүсэлт 11%-иар буурч, эвлэрүүлэн зуучлалд хамрагдах хосын тоо 30%-иар өссөн эерэг үр дүн гарчээ. Гэхдээ тус зохицуулалт нь гэр бүл цуцлахдаа буруутай этгээд тогтоохоос татгалздаг боловч гэр бүлийн хүчирхийллийг үл тоодог зохицуулалт биш бөгөөд хүчирхийллийн нөхцөлд эвлэрүүлэн зуучлалаас чөлөөлөх, хохирогчийг яаралтай хамгаалах шийдвэр гаргах, хүүхдийн асрамжийг хүчирхийлэл үйлдсэн этгээдэд олгохгүй байх зэрэг тусгай хамгаалалтын механизм бие даан хэрэгждэг. Энэ нь гэр бүл цуцлалтыг хялбарчлахын зэрэгцээ хүний эрх, ялангуяа хохирогч болон хүүхдийн аюулгүй байдлыг илүү бодитоор хамгаалж байгаагаараа онцлог юм. (Family Court Statistics Quarterly: April to June 2024)

Тус улсын гэр бүл цуцлалтын эрх зүйн зохицуулалт нь “хэн буруутай вэ?” гэдгийг тогтоохоос илүүтэйгээр “гэрлэлт бодитоор цааш үргэлжлэх боломжтой эсэх”-д төвлөрдөг онцлогтой. Гэрлэлт цуцлуулахдаа тодорхой үндэслэл нотлох шаардлагагүй бөгөөд “хамтын амьдрал үргэлжлэх боломжгүй болсон” гэх тайлбарыг хангалттай тооцдог. Шүүхийн шатанд хэрэгждэг эвлэрүүлэн зуучлал нь талуудын сайн дурын, бодит үр дүнд чиглэсэн хэлбэртэй байж, эвлэрэх эсхүл цаашдын харилцааг зохицуулахад чиглэдэг. Мөн гэр бүл цуцлалтыг нийгмийн сөрөг үзэгдэл бус бодит нийгмийн нөхцөл хэмээн үзэж, төрөөс хэт оролцох бус зохицуулах замаар хандаж байгаа нь онцлог юм.

Явцын дүгнэлт

Их Британи болон Монгол Улсын гэр бүл цуцлалтын эрх зүйн зохицуулалт нь үзэл баримтлалын хувьд ялгаатай. Их Британи улс гэрлэлт цаашид бодитоор оршин тогтнох боломжгүй болсон эсэхийг гол шалгуур болгосон “no fault divorce” загварыг

хэрэгжүүлдэг бол Монгол Улсад гэр бүл цуцлалтын бодит шалтгаан хуульд тодорхой тусгагдаагүй, шүүхийн практикт “зан харьцаа таарамжгүй”, “үл ойлголцол” зэрэг ерөнхий үндэслэлээр тайлбарлагдсаар байна. Энэ нь салалтын бодит шалтгаан, түүнд нөлөөлсөн нийгэм, сэтгэл зүйн хүчин зүйлсийг тодорхойлох боломжийг хязгаарлаж, хүүхдийн эрхийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх бодлогын үр нөлөөг сулруулж байна.

Хэдийгээр Их Британи болон Монгол Улс нь хүн амын тоо, нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшнээрээ ялгаатай боловч эдгээрийг харьцуулан судалснаар гэр бүл цуцлалтын талаарх эрх зүйн үзэл баримтлал, бодлогын чиг хандлагын ялгааг тодорхой харуулах боломжтой. Судалгаанд Их Британийг сонгон авсан нь түүний нийгэм-эдийн засгийн загварыг шууд нутагшуулах зорилготой бус, харин гэр бүл цуцлалтыг буруутай этгээдэд тулгуурлахгүйгээр, гэрлэлтийн бодит задралыг шалгуур болгодог эрх зүйн хандлагыг илрүүлж, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжтой зарчмыг тодорхойлох зорилготой болно.

Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын гэр бүлийн эрх зүйн харилцааг “Иргэний хууль” (민법, Civil Act) болон “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” (가사소송법, Family Litigation Act)-аар тус тус зохицуулдаг. Гэрлэлт цуцлахтай холбоотой маргааныг тухайн улсын гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр мэргэшсэн шүүхээр шийдвэрлэдэг бөгөөд хүүхдийн тэтгэмжтэй холбоотой харилцааг бие даасан хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулжээ.

Тус улсад хүүхдийн эрхийн асуудлыг хамгийн түрүүнд авч үздэгээрээ давуу талтай бөгөөд БНСУ-д гэр бүл цуцлах үед хүүхдийн асрамжийн эрх, тэтгэлэг, дундын эд хөрөнгийн хуваарилалтыг шүүх шийддэг байна. 2013 оноос эхлэн “Хүүхдийн асрамж ба уулзалтын эрхийг хангах тухай журам” (Child Custody and Visitation Guidelines) болон 2008 онд батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-д зааснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид хуулийн дагуу хориг арга хэмжээ авч, хохирогчийг хамгаалах, түр хоргодох байр олгох зэрэг зохицуулалт бий.

Хүснэгт 2.14 Өмнөд Солонгос улсын гэрлэлт цуцлах хэлбэр

Гэр бүл цуцлах хэлбэр	Хууль зүйн тодорхойлолт
-----------------------	-------------------------

Харилцан зөвшөөрлөөр (Mutual Consent Divorce, 협의이혼)	Харилцан зөвшөөрлөөр гэр бүл цуцлах тохиолдолд хоёр тал гэрлэлтээ цуцлуулах тухай хүсэлтээ шүүхэд хамтран гаргаж, тодорхой хугацааны дараа (ихэвчлэн 1–3 сар) баталгаажуулдаг. Энэ хугацаанд шүүх гэрлэгчдэд эвлэрэх боломж байгаа эсэхийг судалж, ялангуяа дундаа үр хүүхэдтэй гэр бүлийн хувьд заавал эвлэрүүлэн зуучлах үе шатыг хийх шаардлагатай байдаг.
Шүүхийн шийдвэрээр гэрлэлт цуцлах (Judicial Divorce, 재판상이혼)	Иргэний хуулийн 840 дүгээр зүйлд заасан гэр бүл цуцлах үндэслэл: • Гэрлэгчдийн хэн нэг нь араар тавих буюу хууран мэхлэх, үнэнч бус байх (adultery) • Гэрлэгчдийн хэн нэг нь нөгөө талаа хаяж явсан • Хосуудын хэн нэг нь нөгөөгөө доромжилсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн • Гурав буюу түүнээс дээш жилийн хугацаанд оршин суугаа газраа орхин явах, сураггүй алга болох • Угсаа залгамжлах хүндээ шударга бус хандах • Бусад ноцтой шалтгаан (шүүхийн үзэмжээр)

Эх сурвалж: Article. 834, 840 Korean Civil Act. <https://international-divorce.com/d-korea/#:~:text=Grounds%20For%20Divorce%20in%20Korea,difficult%20to%20continue%20the%20marriage.>

БНСУ-ын Иргэний хуулийн 841, 842 дугаар зүйл. Гэр бүл цуцлах хүсэлт гаргах хугацааны зохицуулалтыг тусгаж өгсөн байдаг.

- 841 дүгээр зүйл. Гэр бүл цуцлах нэхэмжлэл гаргах хугацаа

Хэрэв гэрлэгчдийн гэр бүл цуцлах шалтгаан нь хууран мэхлэлт (adultery), хүчирхийлэл, эсвэл бусад ноцтой буруу үйлдэл бол тухайн нөхцөл байдлыг мэдсэн өдрөөс хойш 6 сарын дотор, мөн тухайн үйлдэл гарсан өдрөөс хойш 2 жилийн дотор нэхэмжлэл гаргах ёстой.

Энэ зүйлд зааснаар, гэрлэлтээ цуцлуулах хүсэлт гаргасан тал нь цаг хугацааны хувьд хөөн хэлэлцэх хугацаа зааж өгсөн байдаг гэсэн үг. Хэрвээ энэ хугацаа өнгөрвөл хүсэлт гаргасан тал гэр бүл цуцлуулах нэхэмжлэл гаргах эрхээ алддаг. Энэ нь “хугацаа хэтэрсэн” гэсэн шалтгаанаар гэр бүл цуцлахыг хязгаарлаж, хууль зүйн тогтвортой байдлыг хангах зорилготой.

- 842 дугаар зүйл. Гэр бүл цуцлуулах нэхэмжлэл гаргах эрхээ алдах

Хэрэв гэрлэгчдийн аль нэг тал нөгөө талын буруутай үйлдлийг уучилсан, эсвэл гэр бүлийн харилцаагаа эргээд сэргээсэн бол тухайн гэм буруутай шалтгаанд тулгуурлан гэр бүл цуцлах нэхэмжлэл гаргах эрх нь хүчингүй болдог.

Шүүх нь гэр бүл цуцлах хүсэлтийг хүлээн авсны дараа заавал эвлэрүүлэн

зуучлалын үе шат (mediation stage) явуулдаг. Энэ үе шатанд гэрлэгчдэд гэр бүлийн харилцааг хадгалах боломж байгаа эсэхийг судалж, хүүхдийн асрамж, эд хөрөнгийн эрхийн хуваарилалт, тэтгэмж, тэтгэлгийн асуудлыг авч үздэг. Үүгээрээ Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалттай төстэй.

БНСУ-ын хувьд тус улс нь иргэдийнх нь гэрлэлтийн түвшин жил тутам эрс буурч байгаа улсын нэг юм. 2011 оны байдлаар улс даяар 329 мянган хос гэрлэж байсан бол арван жилийн дараа 2021 он гэхэд энэ тоо 192 мянгад хүрч, арван жилийн дотор бараг 58 хувиар буюу 200 мянгаар буурсан нь томоохон өөрчлөлт болсон юм.

Хүснэгт 2.15 БНСУ – Гэр бүл цуцлалтын тоо (2010-2024)

Жил	Гэр бүл цуцлалтын тоо
2010	116,858
2015	109,153
2020	106,500
2021	101,673
2022	93,232
2023	92,394
2024	91,151

Эх сурвалж: https://countryeconomy.com/demography/divorces/south-korea?utm_source

Тус статистик мэдээллээс харахад 2010-2024 оны хооронд БНСУ-д бүртгэгдсэн гэр бүл цуцлалтын тоо тогтвортой буурах хандлагатай байна. 2010 онд 116,858 гэр бүл цуцлалт бүртгэгдэж байсан бол 2024 онд энэ тоо 91,151 болж, нийт 22%-иар буурсан байна. Энэхүү гэр бүл цуцлалтын бууралт нь нийгмийн бүтцийн өөрчлөлт, гэр бүлийн талаарх ухамсар нэмэгдэх, төрийн бодлого, төрөлт багасах зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой юм. Гэр бүл цуцлалтын түвшинг тус улсын нийгэм, соёлын хүчин зүйлсийн нөлөөгөөр авч үзвэл дараах шалтгаанууд гол байр суурь эзэлж байна. Үүнд:

- Эдийн засгийн тогтворгүй байдал ба ажлын байрны дарамт: Залуу гэр бүлүүдийн хувьд амьдралын өртөг, ажил, орлогын ялгаа нь гэр бүлийн тогтвортой байдалд их, бага хэмжээгээр нөлөөлж байна.
- Нийгмийн хандлагын өөрчлөлт: Өмнөд Солонгос улсын нийгэмд уламжлалт гэр бүлийн үзэл өмнөх цаг үеэ бодвол илүү уян хатан болж, гэр бүлээ цуцлуулах шийдвэрийг нийгэм болон гэр бүлийн бусад гишүүд илүү хүлээн зөвшөөрөх

болсонтой холбоотой. Мөн эмэгтэйчүүдийнх нь бие даасан, хараат бус байдал нэмэгдэхийн хэрээр гэрлэлтийн талаарх хандлага эрс өөрчлөгдөж байна.

Тус улсын гэр бүл цуцлах томоохон шалтгаануудад:

- Хоорондын таарамжгүй байдал;
- Санхүүгийн асуудал;
- Үнэнч бус байдал;
- Гэр бүлийн бусад гишүүд буюу хадмуудтайгаа таарамжгүй зэрэг үндэслэл дээгүүр байр суурь эзэлдэг байна.

БНСУ-д гэр бүлээс гадуурх харилцаа буюу араар тавих үйлдэл нь 2015 оноос эхлэн эрүүгийн гэмт хэрэгт тооцогдохоо больсон боловч Иргэний эрх зүйн хүрээнд хууль бус үйлдэл хэвээр үлдсэн бөгөөд гэр бүл цуцлах тохиолдолд гэрлэгчдийн хэн нэг нь буруутайд тооцогдох салалтын гол үндэслэл хэвээр байна. Тус улсын Иргэний хуулийн 840 дүгээр зүйлд гэр бүлээс гадуурх харилцааг шүүхийн журмаар гэр бүл цуцлах нэгдүгээр үндэслэл болгон тодорхой заасан нь онцлог юм.

БНСУ-ын эрх зүйн зохицуулалтын нэг чухал онцлог нь гэр бүлээс гадуурх харилцаа үйлдсэн, өөрөөр хэлбэл буруутай тал нь гэр бүл цуцлах ажиллагаанд тодорхой эрх зүйн хязгаарлалт, сөрөг үр дагаврыг хүлээдэгт оршино. Тухайлбал:

- Буруутай этгээд өөрөө гэр бүл цуцлах нэхэмжлэл гаргах эрхгүй байх зарчим үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, гэр бүлээс гадуурх харилцаа үйлдсэн эхнэр эсхүл нөхөр нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрлэлт цуцлуулах боломжгүй бөгөөд ингэснээр хохирсон талд гэрлэлтээ хадгалах эсэхийг шийдэх бодит эрх зүйн боломж олгодог.
- Хохирсон эхнэр эсхүл нөхөр нь тус улсын Иргэний хуулийн 750, 751 дүгээр зүйлд зааснаар сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр (consolation money, wi-ja-guo) шаардах эрхтэй. Энэхүү нэхэмжлэлийг зөвхөн буруутай эхнэр эсхүл нөхрөөс гадна гэр бүлээс гадуурх харилцаанд оролцсон гуравдагч этгээдэд ч гаргах боломжтой байдаг. Шүүхийн практикт гуравдагч этгээдээс гаргуулж буй нөхөн төлбөрийн хэмжээ дунджаар 10-50 сая воны хооронд хэлбэлздэг бөгөөд уг хэмжээ нь араар тависан харилцааны хугацаа, хэр зэрэг ноцтой вэ зэргээс хамааран тогтоогддог. Түүнчлэн уг нэхэмжлэлийг заавал гэр бүл цуцалсны дараа бус, гэрлэлт хэвээр байгаа үед ч гаргах боломжтой нь хохирлыг бодитой нөхөн

төлүүлэхэд чиглэсэн зохицуулалт юм. Гэхдээ үүнд хөөн хэлэлцэх хугацаа хамаардаг бөгөөд гэм буруутай үйлдлийг мэдсэн өдрөөс хойш 3 жилийн дотор, эсхүл тухайн араар тавилт эхэлснээс хойш 10 жилийн дотор нэхэмжлэлээ гаргах ёстой байдаг.

- Эд хөрөнгийн хуваарилалтад гэр бүлээс гадуурх харилцаа тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. Хэдийгээр БНСУ-д дундын эд хөрөнгийг үндсэндээ эхнэр, нөхрийн оруулсан хувь нэмэрт тулгуурлан тэнцвэртэй хуваарилах зарчим баримталдаг боловч буруутай этгээдийн үйлдэл нь шүүхийн үзэмжид нөлөөлж, түүний авах хувь багасах нөхцөл бүрддэг.
- Хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ шүүх “хүүхдийн хамгийн сайн ашиг сонирхол” буюу “Best of Interest” -ыг тэргүүн ээлжид харгалздаг хэдий ч гэр бүлээс гадуурх харилцаа нь тухайн эцэг, эхийн хүүхдээ хүмүүжүүлэх чадвар, үүрэг, хариуцлагад сөргөөр нөлөөлсөн эсэхийг үнэлэх шалгуурын нэг болдог.

Харин Монгол Улсын хувьд гэр бүлээс гадуурх харилцаа нь Гэр бүлийн тухай хуульд гэр бүл цуцлах бие даасан хууль ёсны үндэслэл мөн эсэх, дундын эд хөрөнгийн хуваарилалт, тэтгэмж, хүүхдийн асрамжид хэрхэн нөлөөлөх талаар тодорхой зохицуулалтгүй хэвээр байна. Үүний улмаас шүүхийн практикт гэр бүлээс гадуурх харилцаа нь “хоорондын таарамжгүй харилцаа”, “итгэлцэл алдагдсан” гэх ерөнхий үндэслэлд орж, эрх зүйн хувьд тодорхой бус, субъектив байдлаар үнэлэгдэх хандлага давамгайлж байна.

Явцын дүгнэлт

БНСУ нь гэр бүл цуцлах үндэслэлийг хуульд тодорхой тусган, шүүхийн практикийг нэг мөр болгосноор гэрлэгчдийн эрхийг бодитоор хамгаалах боломжийг бүрдүүлсэн байна. Харин Монгол Улсад гэр бүл цуцлах материаллаг үндэслэл тодорхой бус хэвээр байгаа нь шүүхийн практик давамгайлах, ижил төрлийн хэрэгт зөрүүтэй шийдвэр гарах, хүүхдийн эрх хангалттай хамгаалагдахгүй байх нөхцөлийг үүсгэж байна.

Түүнчлэн эвлэрүүлэн зуучлах тогтолцооны хувьд БНСУ-д уг ажиллагааг гэр бүлийн зөвлөгөө, сэтгэл зүйн үйлчилгээтэй уялдуулан хэрэгжүүлдэг нь бодит үр дүн өгч байгаа бол Монгол Улсад эвлэрүүлэн зуучлал ихэвчлэн формаль шинжтэй, мэргэжлийн дэмжлэгтэй уялдах нь сул, үр нөлөө багатай байна.

БНСУ-д гэр бүлээс гадуурх харилцааг эрүүгийн гэмт хэрэгт тооцохоо больсон хэдий ч иргэний эрх зүйн хүрээнд гэр бүл цуцлах бие даасан үндэслэл

хэвээр хадгалж, буруутай гэрлэгчид тодорхой эрх зүйн хязгаарлалт, сөрөг үр дагаврыг оногдуулах замаар хохирсон талын эрх, ашиг сонирхлыг бодитоор хамгаалж байна. Тодруулбал, буруутай талын гэр бүл цуцлах эрхийг хязгаарлах, сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр шаардах, эд хөрөнгийн хуваарилалт болон хүүхдийн асрамжийн асуудалд тухайн үйлдлийг үнэлэх зэрэг нь шүүхийн шийдвэрийг илүү тодорхой, урьдчилан таамаглах боломжтой болгожээ.

Харин Монгол Улсад гэр бүлээс гадуурх харилцааны эрх зүйн үр дагаврыг хуульд тодорхой тусгаагүйгээс уг үйлдэл нь шүүхийн практикт ерөнхий, агуулгын хувьд тодорхой бус үндэслэлд шингэж, субъектив байдлаар үнэлэгдэх нөхцөл бүрдэж байна. Иймд БНСУ-ын туршлагаас харахад гэр бүлээс гадуурх харилцааны эрх зүйн үр дагаврыг хуульд тодорхой заах нь шүүхийн практикийг нэг мөр болгох, эрх зүйн тодорхой байдлыг хангах, хохирсон тал болон хүүхдийн эрх ашгийг илүү үр нөлөөтэй хамгаалах ач холбогдолтой юм.

ДҮГНЭЛТ

Энэхүү дипломын ажлын хүрээнд Монгол Улсад гэр бүл цуцлахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, шүүхийн практик, мөн ОХУ, Япон, Их Британи, БНСУ зэрэг улс орнуудын туршлагыг харьцуулан судалж, дараах үндсэн дүгнэлтэнд хүрлээ.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсад гэр бүл цуцлалтын тоо сүүлийн жилүүдэд тогтмол өсөх хандлагатай байгаа бөгөөд иргэний хэрэг маргаанд эзлэх гэр бүлийн маргааны дийлэнх хувийг гэрлэлт цуцлах нэхэмжлэл бүрдүүлж байна. Гэр бүл цуцлалтад нөлөөлж буй гол хүчин зүйлсэд гэр бүлийн хүчирхийлэл, харилцааны таарамжгүй байдал, санхүүгийн хүндрэл, архидалт, үнэнч бус байдал зэрэг нийгэм-сэтгэл зүйн шалтгаанууд зонхилж байна.

Гэр бүл цуцлах ажиллагаанд мөрдөгдөж буй одоогийн эрх зүйн зохицуулалт, ялангуяа эвлэрүүлэн зуучлах ажиллагааг заавал хэрэгжүүлэх, гэр бүлийн харилцаатай байсныг нотлох баримтад өндөр шаардлага тавих зэрэг нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, шүүхийн шийдвэрлэлтийг удаашруулах бодит эрсдэлийг бий болгож байна. Үүний улмаас хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдах, эвлэрүүлэн зуучлал бодит үр нөлөөгүй процедур болон хувирах нөхцөл бүрдэж байна.

Харьцуулсан судалгаанаас харахад гадаад улс орнууд, тухайлбал Их Британи улсын “no-fault divorce” тогтолцоо, БНСУ-ын хүүхдийн эрх, тэтгэмж, дундын хөрөнгийн асуудлыг нарийвчлан зохицуулсан эрх зүйн шийдлүүд нь Монгол Улсад нутагшуулан хэрэгжүүлэх боломжтой сайн туршлага юм. Эдгээр нь гэр бүл цуцлах процессыг хөнгөвчлөх, хүүхдийн эрх ашгийг бодитоор хамгаалах, шүүхийн ачааллыг бууруулах ач холбогдолтой.

Мөн судалгаанд үндэслэн гэр бүл цуцлах хууль зүйн үндэслэлийг илүү тодорхой, уян хатан байдлаар хуульчлах, гэр бүлийн хүчирхийлэлтэй хэргүүдийг эвлэрүүлэн зуучлалаас ангид авч үзэх, нотлох баримтын босгыг зөөлрүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах тусгай журам бий болгох шаардлагатай гэж үзлээ. Энэ хүрээнд 2026 оноос хэрэгжихээр төлөвлөгдөж буй “Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх” нь Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн хамгаалалтыг шинэ шатанд гаргах бодит боломж гэж дүгнэж байна.

Эцэст нь гэр бүл цуцлалтыг зөвхөн хууль зүйн хүрээнд авч үзэхээс гадна нийгмийн халамж, гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө, хүүхэд хамгааллын үйлчилгээ, орлогын баталгааг дэмжих бодлого зэрэг олон талт арга хэмжээтэй уялдуулах нь гэр бүлийн тогтвортой байдлыг хамгаалах урт хугацааны үр нөлөөтэй болно гэж үзэв.

Түүнчлэн эмэгтэйчүүдийн санхүүгийн болон боловсролын бие даасан байдал нь гэр бүл цуцлалтад шууд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл бус, харин тухайн улсын нийгэм-эдийн засгийн бүтэц, соёл, хүйсийн үүргийн хуваарилалтаас хамааран хувьсан өөрчлөгдөх үзэгдэл болох нь судалгаагаар тогтоогдлоо. Орчин үеийн нөхцөлд энэ байдал нь гэр бүлийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх боломжтой юм.

Дипломын ажлын хүрээнд хийсэн харьцуулсан судалгаанд үндэслэн Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн зохицуулалтад гадаад орнуудын туршлагаас:

- Эвлэрүүлэн зуучлалыг мэргэжлийн сэтгэл зүйч, гэр бүлийн зөвлөгөөтэй холбогдуулан хэрэгжүүлэх үр нөлөөтэй загварууд
- Хүүхдийн эрхийг хамгаалах стандарт
- Гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэсэн буруутай гэрлэгчид хуулийн дагуу арга хэмжээ авах, сэтгэл санааны нөхөн олговрыг БНСУ-ын жишгээс тусгайлан хуульчлах
- Гэр бүл цуцлалтын үеийн шүүхийн процессыг хөнгөвчлөх арга болон эвлэрүүлэн зуучлалын механизмыг хэрэгжүүлэхдээ илүү хатуу, албадлагын шинжтэй зохицуулалтыг зөөлрүүлэх зэргийг өөрийн улсын нийгэм, соёлын түвшинд хэрэгжүүлэх боломжтой.

2021-2023 онд бүртгэгдсэн гэрлэлт, гэрлэлт цуцлалтын статистикаас үзэхэд дунджаар дөрвөн гэрлэлт тутмын нэг нь салалтаар төгсөж байгаа нь хүүхдийн эрх ашиг тогтмол хөндөгдөж буйг илтгэнэ. Гэсэн хэдий ч гэр бүл салалтын суурь шалтгаан, нөхцөлийг нарийвчлан судалж, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодитой арга хэмжээ хангалтгүй хэвээр байна. Ялангуяа таарамжгүй харилцаанаас үүдэлтэй салалт зонхилж байгаа нөхцөлд хос, гэр бүлд чиглэсэн зөвлөгөө, сэтгэл зүйн үйлчилгээний хүртээмж, чанар сул, мэргэжлийн боловсон хүчний дутагдал ноцтой асуудал болж байна.

Түүнчлэн нийгэм-эдийн засгийн тогтворгүй байдал, орлого буурах, ажилгүйдлийн асуудал зэрэг нь гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлсөөр байгаа бөгөөд үүнийг бууруулахад чиглэсэн төрөөс хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө хангалтгүй байна. Үүнээс гадна гэр бүлийн боловсрол олгох тогтолцоо бүх шатанд сул, ерөнхий боловсролын хөтөлбөрт системтэйгээр тусгагдаагүй, мэргэшсэн багш, арга зүйн дэмжлэг дутмаг байгаа нь хариуцлагатай гэр бүлийг төлөвшүүлэхэд саад болж байна. Иймд гэр бүл цуцлалтыг зөвхөн хууль зүйн маргааны хүрээнд бус, нийгмийн халамж, сэтгэл зүйн зөвлөгөө, хүүхэд хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, орлогын баталгааг дэмжих бодлоготой уялдуулсан цогц хандлагаар зохицуулах нь гэр бүлийн тогтвортой байдлыг хангах урт хугацааны ач холбогдолтой гэж дүгнэлээ.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Гэр бүл цуцлах үндэслэл, үйл явц болон тулгамдсан асуудлын талаарх харьцуулсан судалгааны үр дүнд дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

Гэр бүл цуцлах маргааныг эвлэрүүлэн зуучлах тогтолцооны хүрээнд зохистой хуульчлах: Монгол Улсад эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа хуульчлагдсан боловч гэр бүлийн маргаанд хэрэгжих үр нөлөө хангалтгүй, мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч болон тусгайлсан институцийн тогтолцоо дутмаг байна. Гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын бус, сэтгэл санааны болон эдийн засгийн хэлбэртэй байдгийг харгалзан үзэж, хүчирхийлэл байгаа эсэхийг нотлох өндөр босго тавилгүйгээр шүүх тухайн маргааныг шууд хүлээн авах боломжийг өргөжүүлэх шаардлагатай. Энэ нь хохирогчийг дахин эрсдэлд оруулах, процессын чирэгдэл үүсэхээс сэргийлнэ. Мөн Япон улсын туршлагад тулгуурлан гэр бүлийн маргаанд оролцох эвлэрүүлэн зуучлагчийг сэтгэл зүй, гэр бүлийн эрх зүй, хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн байх шаардлагыг хуульчлах нь зүйтэй.

Гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх: Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн талаарх боловсрол, мэдлэгийн түвшин хангалтгүй байгаа нь гэр бүл цуцлалтад нөлөөлөх суурь хүчин зүйлсийн нэг болж байна. Иймд гэр бүлийн боловсролыг хүүхдэд бага наснаас нь үе шаттайгаар олгох, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт гэр бүл, эцэг эхийн хариуцлага, харилцааны ур чадварыг төлөвшүүлэх агуулгыг системтэйгээр тусгах нь зүйтэй. Тухайлбал, Япон улсад ахлах ангийн сурагчдыг богино хугацаанд хүүхэд асрах, гэр бүлийн амьдралд ойр нөхцөл байдлыг туршлагаар мэдрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлдэг нь гэр бүлтэй болох, эцэг эх байх хариуцлагыг ойлгуулах үр дүнтэй жишиг болж байна.

Гэр бүл цуцлах үндэслэлийг тодорхой, уян хатан байдлаар хуульчлах: Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэр бүлийн тухай хуульд гэр бүл цуцлах материаллаг үндэслэл тодорхой заагдаагүй нь шүүхийн үзэмжийг хэт өргөн хэрэглэх, улмаар ижил төрлийн маргаанд ялгаатай шийдвэр гарах нөхцөл бүрдүүлж байна. Иймд гэр бүл цуцлалтад хүргэдэг голлох шалтгаануудыг жишиг байдлаар тодорхойлж, тухайн нөхцөл байдлыг уян хатан үнэлэх боломжийг хадгалсан зохицуулалтыг БНСУ, Япон улсын эрх зүйн туршлагад нийцүүлэн Гэр бүлийн тухай хуульд тусгах нь зүйтэй.

Гэр бүлд чиглэсэн салбар дундын цогц бодлогыг боловсронгуй болгох: Гэр бүлийн харилцаанд гарч буй орчин үеийн өөрчлөлт, гэр бүлийн бүтэц, хэрэгцээний ялгаатай байдлыг харгалзан гэр бүлд чиглэсэн боловсрол, нийгмийн хамгаалал, орон сууц, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг уялдуулсан салбар дундын

цогц бодлогыг тогтвортой санхүүжилттэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гэр бүл цуцлалтад араар тавилт үйлдсэн буруутай гэрлэгчийн үүрэг, хариуцлага болон эд хөрөнгийн эрхийг уялдуулсан зохицуулалтыг хуульчлах: Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9.2.8-д “эд хөрөнгийн болон сэтгэл санааны хохирлоо буруутай гэрлэгчээс гаргуулах эрхтэй”, мөн 9.4-т “гэр бүлээс гадуурх харилцааны улмаас гэрлэлт цуцалсан тохиолдолд буруутай гэрлэгчээс сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ” гэж заасан боловч уг сэтгэл санааны хохирлын хэмжээг тогтоох шалгуур, нөхөн төлүүлэх хэлбэр, эд хөрөнгийн харилцаатай уялдуулах зохицуулалт тодорхой бус хэвээр байна. Энэхүү сул талыг арилгах үүднээс БНСУ-ын гэр бүлээс гадуурх харилцаатай холбоотой маргааныг Гэр бүлийн тухай хууль болон шүүхийн практикт тогтсон зохицуулалтыг жишиг болгон авч үзэх нь зүйтэй. Тухайлбал, гэрлэгчдийн хоорондын үнэнч байх үүргийг зөрчсөн үйлдлийг иргэний эрх зүйн зөрчилд тооцож, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхийн зэрэгцээ эд хөрөнгийн хуваарилалтад тухайн буруутай үйлдлийг харгалзан үзэх боломжийг хуульчлах нь гэр бүлийн харилцаанд хариуцлагын зарчмыг бэхжүүлэх, буруутай зан үйлд хууль зүйн хариуцлага тооцох, цаашлаад гэр бүл цуцлалтад хүргэх эрсдэлийг бууруулах бодит ач холбогдолтой юм.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх

- 1.Бүрэнжаргал, Т. (2005). *Гэр бүлийн социологи (7-р тал)*. Улаанбаатар, МУИС-ийн ХЭВЛЭХ.
- 2.Бүрэнжаргал, Т. (2022) *Гэр бүл салалтад хийсэн социологийн шинжилгээ*, Улаанбаатар, Монгол.
- 3.Дугармаа, А. (2016). *Гэр бүлийн эрх зүй (41-р тал)*. Улаанбаатар, Адмон хэвлэл
- 4.Дугармаа, Б. (2019). *Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал (112-р тал)*. Улаанбаатар, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, №4.
- 5.Мөнхжаргал, Т. (1995). *Гэр бүлийн эрх зүй (3-р тал)*. Улаанбаатар, Эрдэм хэвлэл
- 6.Нарантуяа, Ж. (2002) *Монголын өнөөгийн гэрлэлт, цуцлалтын байдал*. Магистрын зэрэг горилсон дипломны судалгааны ажил, Улаанбаатар, Монгол.
- 7.Норовдондог, Ц., Аюуш, Д., Амаржаргал, Д., Нарантуяа, О., Жигваагүнсэл, Д., Батцэцэг, Б., Оргилмаа, Р. (2022) *Гэр бүл салалт, гэр бүлийн харилцааны зөрчил шийдвэрлэлтийн талаарх бусад орнуудын туршилага ба Монгол улсын нөхцөл байдал, харьцуулсан судалгаа*, Парламент судалгааны эмхэтгэл, боть 39.
- 8.Оюун-Эрдэнэ, Б. *Эмэгтэйчүүдийн хөгжил цэцэглэл үндэсний чуулганд зориулсан илтгэл*, Улаанбаатар, Монгол.
- 9.Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, (2020-2024), *Гэрлэлтээ батлуулсан хүний тоон статистик*, <https://www.1212.mn/>
- 10.Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, (2020-2024), *Гэр бүл цуцлалтын тоон статистик*, <https://www.1212.mn/>
- 11.Хууль зүйн үндэсний хүрээлэн, *Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн судалгааны тайлан*, Улаанбаатар, 2021.
- 12.Хууль зүй дотоод хэргийн яам. *Гэр бүл, хүүхдийн холбогдолтой хэргийг шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хууль тогтоомжид хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн тайлан*. Улаанбаатар, 2024.
- 13.Хууль зүй дотоод хэргийн яам. *Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээний тайлан*. Улаанбаатар, 2025.

14. Хүний эрхийн үндэсний комисс. (2024) *Гэр бүлийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал*. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн дөрөвдүгээр бүлэг, Улаанбаатар, Соёмбо принтинг.
15. Шүүхийн ерөнхий зөвлөл. *Монгол Улсын шүүхийн тайлан*. Улаанбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөл, 2020. 2021 оны эхний хагас жил.
16. Энхжаргал, Т. (1999). *Гэрлэлт цуцлалт, түүний үр дагаврыг шийдвэрлэх арга хэлбэрийн асуудал*. Хууль зүйн магистрын зэрэг горилсон судалгааны ажил, Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар, Монгол.

Гадаад хэл дээрх

1. Abedinia, N., Bolhari, J., Ramezanzadeh, F., & Naghizadeh, M. M. (2012). *Comparison of predisposing and effective factors on divorce application between men and women*. Journal of Family and Reproductive Health, 6(2), 65–72.
2. Брачное и семейное право по КЗАГС РСФСР 1918 г (1998)
3. Семейный кодекс Российской Федерации, N 223-ФЗ (1995)
4. Dong, X. (2018). *Women's Labor Force Participation and Probability of Getting Divorced*.
5. Economic Independence and Marital Dissolution: A Review. *Center for Demography and Ecology Working Paper 1992-28*, University of Wisconsin. Retrieved from https://cde.wisc.edu/wp-content/uploads/sites/839/2019/02/cde-working-paper-1992-28.pdf?utm_source
6. Family Law Act, c. 27 (1996).
7. Goldman, W. Z. (1993). *Women, the state and revolution: Soviet family policy and social life, 1917–1936*. Cambridge University Press.
8. Killewald, A. (2016). *Money, Work, and Marital Stability: Assessing Change in the Gendered Determinants of Divorce: Assessing Change in the Gendered Determinants of Divorce*. American Sociological Review, 81(4), 696-719.
<https://doi.org/10.1177/0003122416655340>
9. Korean Civil Act, Article. 834, 840. Retrieved from <https://international-divorce.com/d-korea/#:~:text=Grounds%20For%20Divorce%20in%20Korea,difficult%20to%20continue%20the%20marriage>.
10. LEVIN, E. (1989). *Marriage. In Sex and Society in the World of the Orthodox Slavs 900–1700* (pp. 79–135). Cornell University Press.
<http://www.jstor.org/stable/10.7591/j.ctv5rdxvf.8>

11. Ministry of Justice. (2024). *Family Court Statistics Quarterly: April to June 2024*. Retrieved from <https://www.gov.uk/government/statistics/family-court-statistics-quarterly-january-to-march-2024/family-court-statistics-quarterly-data-quality-statement>
12. Office for National Statistics (2025, July 2). *Divorces and dissolutions in England and Wales: 2023*. Office for National Statistics. Retrieved from <https://www.ons.gov.uk/>.
13. *Russia is the top divorcing nation*. Russian divorce statistics. Cit 10/06/2014. Retrieved from Consort Family law website, <https://divorceinrussia.com/russian-divorce-statistics/#:~:text=infidelity%20%5B24%25%5D,15%25%20of%20divorces%20to%20it.>